TDB · ИНТЕРНЭТ БАНК

Байгууллагын интернэт банкны заавар

Байгууллагын интернэт банкаар хийх үйлдэл бүрийг эхнээс нь дуустал алхамчлан, дэлгэцийн зурагтай харуулсан заавар.

ГАРЧИГ

Нэвтрэх

Интернэт банкинд нэвтрэх 2
HID Approve-д бүртгүүлэх 14
Бүртгүүлэх, идэвхжүүлэх 26
Нууц үг сэргээх 30
Нэвтрэх нэр сэргээх 43

Нүүр хуудас

Нүүр хуудастай танилцах 44
Мэдэгдэл, цэсээр хайх 46

Данс

Данс, үлдэгдэл харах 48
Дансны хуулга авах 51
Дансны тодорхойлолт авах 52

Шилжүүлэг

Дотоод шилжүүлэг хийх 55
IBAN лавлах 64
Гадаад руу шилжүүлэх (SWIFT) 69
Гадаад гүйлгээ лавлах 85
Тогтмол шилжүүлэг 86
Гүйлгээний загвар 87
Багц шилжүүлэг 89

Гүйлгээний хүсэлт

Гүйлгээ зөвшөөрөх 101
Илгээсэн хүсэлт 104
Гүйлгээний түүх 106

Зээл

Зээлээ харах, төлөх 108

Картын удирдлага

Картын удирдлага 115

Төлбөр

Татвар төлөх 134
Гаалийн төлбөр төлөх 138

Үйлчилгээ

Мэдэгдэл, хүсэлт илгээх 142
Кастодиан 146
Арилжааны хүсэлт 148

Тохиргоо

Хувийн мэдээлэл 153
Дансны тохиргоо 154
Аюулгүй байдлын тохиргоо 158

Дэлгэцийн зургууд тест (DR) орчинд, байгууллагын тест хэрэглэгчээр авагдсан. Данс, дүн, нэрс жишээ зорилготой.

Интернэт банкинд нэвтрэх

Хуучин системээс шилжиж буй болон шинэ системийн хэрэглэгчийн нэвтрэх алхам ялгаатай. Өөрт тохирохыг сонгоно.


ХОЛБООТОЙ ЗААВАР HID Approve-д бүртгүүлэх · Аюулгүй байдлын тохиргоо

ХУВИЛБАР 1 / 2

Хуучин системээс шилжиж буй

ЗАМ Интернэт банкны нэвтрэх хуудас

ДЭЛГЭЦ 1 / 7 **Хуучин нэвтрэх нэр, нууц үг оруулах**




1 Хуучин нэвтрэх нэр
Шинэ системд анх нэвтрэхдээ өмнө хэрэглэж байсан интернэт банкны нэвтрэх нэрээ **Нэвтрэх нэр** талбарт оруулна.

2 Хуучин нууц үг
Нууц үг талбарт хуучин интернэт банкны нууц үгээ оруулна. Нүдний дүрс дээр дарж бичсэнээ харах боломжтой.

3 Үргэлжлүүлэх
Хоёр талбар бөглөгдсөний дараа **Үргэлжлүүлэх** товч идэвхжинэ. Дарахад баталгаажуулах код оруулах цонх гарна.


ДЭЛГЭЦ 2/7

OTP кодоор баталгаажуулах



1 Нэг удаагийн код


Хуучин TDB OTP апп эсвэл Vasco төхөөрөмж ашигладаг байсан бол тэндээс авсан нэг удаагийн кодоо оруулна.



2 Баталгаажуулах

Кодоо 6 нүдэнд оруулахад **Баталгаажуулах** товч идэвхжинэ. Дарж баталгаажуулна.


ДЭЛГЭЦ 3/7 **Нууц үг шинэчлэх шаардлагатай**



1 **Нууц үг өөрчлөх**


Баталгаажуулалт амжилттай болбол **Нууц үг шинэчлэх шаардлагатай** цонх гарна. Шинэ системд анх нэвтрэхдээ нууц үгээ заавал шинэчлэх тул **Нууц үг өөрчлөх**-ийг дарна.

ДЭЛГЭЦ 4/7 **Шинэ нууц үг үүсгэх**



1 **Шинэ нууц үг**


Шинэ нууц үгээ хоёр талбарт ижил оруулна. Нууц үг 8–20 тэмдэгт, дор хаяж 1 том үсэг, 1 жижиг үсэг, 1 тоо, 1 тусгай тэмдэгт агуулна.



2 **Үргэлжлүүлэх**

Хоёр талбарыг бөглөхөд **Үргэлжлүүлэх** товч идэвхжинэ. Дарж нууц үгээ шинэчилнэ.

Нууц үг амжилттай сэргээгдлээ




1 **Нэвтрэх**

Нэвтрэх-ийг дарж нэвтрэх хуудас руу очоод шинэ нууц үгээрээ нэвтэрнэ. Нэвтрэх нэр хэвээр үлдэнэ. Дараа нь төхөөрөмж баталгаажуулах цонх гарна.

Санамж

Хуучин системээс шилжиж буй хэрэглэгчийн нэвтрэх, нууц үг шинэчлэх алхам зөвхөн анх удаа нэвтрэхэд хийгдэнэ. Шинэ системд нэг удаа амжилттай нэвтэрсний дараа **Шинэ системийн хэрэглэгч** алхмаар нэвтэрнэ.

Шинэ төхөөрөмж баталгаажуулах



1 **Төхөөрөмж хадгалах**

Өөрийн төхөөрөмж бол **Төхөөрөмж хадгалах**-ыг чагтална. Чагталбал дараагийн удаа энэ төхөөрөмжөөс нэвтрэхэд дахин баталгаажуулахгүй.


2 **Баталгаажуулах суваг**

Мессеж, **И-мэйл**, **HID Authenticator** сувгийн аль нэгийг сонгон баталгаажуулна. Мессеж, и-мэйлийн мөрөнд бүртгэлтэй утасны дугаар, и-мэйл хаяг хэсэгчлэн нууцлагдаж харагдана.

HID Approve-д бүртгүүлэх →

ДЭЛГЭЦ 7/7

SMS кодоор баталгаажуулах



1 **Код оруулах**


Утсанд ирсэн 4 оронтой кодыг оруулахад **Баталгаажуулах** товч идэвхжинэ, дарна. Тоолуур дууссаны дараа **Шинэ код авах**-аар дахин код авч болно.

ХУВИЛБАР 2/2

Шинэ системийн хэрэглэгч

ЗАМ Интернэт банкны нэвтрэх хуудас

ДЭЛГЭЦ 1/5 Нэвтрэх нэр, нууц үг оруулах



1 Нэвтрэх нэр

Банкнаас олгосон эсвэл бүртгүүлэхдээ үүсгэсэн нэвтрэх нэрээ **Нэвтрэх нэр** талбарт оруулна.

2 Нууц үг


Нууц үг талбарт нууц үгээ оруулна.

3 Үргэлжлүүлэх

Хоёр талбар бөглөгдсөний дараа **Үргэлжлүүлэх** товч идэвхжинэ. Дарж нэвтэрнэ. Шинэ эсвэл хадгалаагүй төхөөрөмжөөс нэвтэрч байгаа бол төхөөрөмж баталгаажуулах цонх гарна.

ДЭЛГЭЦ 2/5

Шинэ төхөөрөмж баталгаажуулах



1 **Төхөөрөмж хадгалах**

Өөрийн төхөөрөмж бол **Төхөөрөмж хадгалах**-ыг чагтална. Чагталбал дараагийн удаа энэ төхөөрөмжөөс нэвтрэхэд дахин баталгаажуулахгүй.


2 **Баталгаажуулах суваг**

Мессеж, **И-мэйл**, **HID Authenticator** сувгийн аль нэгийг сонгон баталгаажуулна. Мессеж, и-мэйлийн мөрөнд бүртгэлтэй утасны дугаар, и-мэйл хаяг хэсэгчлэн нууцлагдаж харагдана.

HID Approve-д бүртгүүлэх →

ДЭЛГЭЦ 3/5

SMS кодоор баталгаажуулах




1 **Код оруулах**

Утсанд ирсэн 4 оронтой кодыг оруулахад **Баталгаажуулах** товч идэвхжинэ, дарна. Тоолуур дууссаны дараа **Шинэ код авах**-аар дахин код авч болно.

ДЭЛГЭЦ 4/5

HID бүртгүүлэх




1 **HID бүртгүүлэх**

HID-д бүртгэлгүй үед энэ цонх гарна. HID Approve нь TDB OTP болон VASCO төхөөрөмжийг орлох баталгаажуулалтын апп бөгөөд байгууллагын хэрэглэгч заавал бүртгүүлэх тул **HID бүртгүүлэх**-ийг дарж эхэлнэ.

HID Approve-д бүртгүүлэх →

Үндсэн данс сонгох



1 **Үндсэн данс**

Нэвтрэх, гүйлгээ хийх, үлдэгдэл шалгахад үндсэн данс автоматаар сонгогдоно. Цонхонд таны дансууд жагсаалтаар харагдана.

2 **Данс сонгох**


Жагсаалтаас ашиглах дансныхаа баруун талын дугуйг сонгоно. Жагсаалтад зөвхөн харилцах болон хугацаагүй хадгаламжийн данс гарна.

3 **Алгасах**

Цонхны баруун дээд буланд байрлах X-ээр алгасаж болно. Үндсэн дансаа дараа нь **Тохиргоо** цэсийн **Үндсэн данс сонгох** хэсгээс тохируулж болно.

4 **Үргэлжлүүлэх**

Нэг данс сонгосны дараа **Үргэлжлүүлэх**-ийг дарна.



5 **Амжилттай**

Үндсэн данс амжилттай тохируулагдлаа! гарна. **Нүүр хуудас**-ыг дарахад **Үндсэн данс** хэсэгт сонгосон дансны үлдэгдэл, дугаар харагдана.

HID Approve-д бүртгүүлэх


Нэвтрэх болон гүйлгээг утсан дээрх HID Approve аппаар баталгаажуулах тохиргоо. Байгууллагын хэрэглэгч заавал бүртгүүлнэ.

ХОЛБООТОЙ ЗААВАР Интернэт банкинд нэвтрэх · Аюулгүй байдлын тохиргоо

ЗАМ Нэвтэрсний дараа гарах «HID бүртгүүлэх» цонх

ЭСВЭЛ Тохиргоо › Аюулгүй байдлын тохиргоо › Давхар баталгаажуулалт


ДЭЛГЭЦ 1/6 HID бүртгүүлэх санал



1 **HID бүртгүүлэх**

Нэвтэрсний дараа гарах цонхны **HID бүртгүүлэх**-ийг дарна. Байгууллагын хэрэглэгчид алгасах товч байхгүй.

HID Approve апп суулгах



1 **Нэг төхөөрөмж**

HID-г зөвхөн нэг төхөөрөмж дээр ашиглах боломжтой тул өдөр тутам биедээ авч явдаг гар утсандаа суулгах нь зүйтэй.

2 **Апп татах**

Гар утсандаа **App Store**, **Google Play**, **Huawei Store** эсвэл **Microsoft Store**-оос **HID Approve** аппыг суулгана. Утасныхаа төрөлд тохирох холбоосыг дарна.


3 **Үргэлжлүүлэх**

Апп суусны дараа **Үргэлжлүүлэх**-ийг дарна. **HID тохиргоо** цонхонд **А. QR кодоор** эсвэл **Б. Гараар** бүртгүүлэх аргаас өөрт тохирохыг сонгоно.

ХУВИЛБАР 1 / 2


A. QR кодоор

ДЭЛГЭЦ 3 / 6 **QR код уншуулах**



1 **QR код таб**


HID тохиргоо цонхны **QR код** таб анхдагчаар сонгогдсон байна. Энэ табд дэлгэц дээрх QR кодыг HID Approve аппаараа уншуулж бүртгүүлнэ.



2 **Аппад: камераар уншуулах**


HID Approve аппыг нээж, **Welcome** дэлгэц дээр дарахад **Add Service** дэлгэц камертайгаа нээгдэнэ. Онлайн банкны QR кодыг камераар уншуулна.

ДЭЛГЭЦ 4/6 Аппад PIN үүсгэх



1 **PIN үүсгэх**


Аппад 4 оронтой PIN код үүсгэж, давтан оруулна. 4 ижил тоо (1111) болон дараалсан тоо (1234) оруулах боломжгүй.



2 **Аппад бүртгэгдсэн**

Аппад **TDB approve service has been registered successfully.** мэдэгдэл гарахад **OK** дарна. Аппын нүүрэнд TDB approve харагдана.


ДЭЛГЭЦ 5/6 **Онлайн банкинд буцаж үргэлжлүүлэх**



1 **Үргэлжлүүлэх**

Аппын бүртгэл дууссаны дараа онлайн банкны **Үргэлжлүүлэх**-ийг дарна.

ДЭЛГЭЦ 6/6 **Амжилттай бүртгэгдлээ**



1 **Амжилттай бүртгэгдлээ**


Цонхонд **Төхөөрөмж амжилттай бүртгэгдлээ. Та уг төхөөрөмжөөс баталгаажуулалт хийх боломжтой боллоо.** гэж гарна. Цаашид гүйлгээ болон бусад үйлдлийг HID Approve аппаараа баталгаажуулна.

2 **Үргэлжлүүлэх**

Үргэлжлүүлэх-ийг дарахад цонх хаагдаж, HID бүртгэлийн өмнө эхлүүлсэн үйлдэл рүүгээ буцна.

Б. Гараар

ДЭЛГЭЦ 3/7 Онлайн банкны «Гараар» таб




1 **Гараар таб**
QR уншуулах боломжгүй бол **Гараар** табыг сонгоно. Табд **Хэрэглэгчийн нэр**, **Түлхүүр нууц үг**, **Холбоос /URL/** гэсэн гурван мэдээлэл харагдана.

2 **Хэрэглэгчийн нэр**
Мөрийн баруун талын **Хуулах**-ыг дарж хуулна. Энэ утгыг аппын **User ID** талбарт оруулна.

3 **Түлхүүр нууц үг**
Мөрийн баруун талын **Хуулах**-ыг дарж хуулна. Энэ утгыг аппын **Invite code** талбарт оруулна.

4 **Холбоос /URL/**
Мөрийн баруун талын **Хуулах**-ыг дарж хуулна. Энэ холбоосыг аппын **Service URL** талбарт оруулна.

Аппад мэдээллээ оруулах




1 **Аппад: Add Service нээх**

HID Approve аппыг нээж **Welcome** дэлгэц дээр дарахад **Add Service** дэлгэц камертайгаа нээгдэнэ.

2 **Аппад: enter invite manually**

Add Service дэлгэцэд **enter invite manually**-г сонгоно. **Service URL** оруулах дэлгэц нээгдэнэ.



3 **Аппад: Service URL**

Онлайн банкны **HID тохиргоо → Гараар** табын **Холбоос /URL/** мөрөөс хуулсан холбоосыг оруулна.

4 **Validate**

Validate-ийг дарж холбоосоо баталгаажуулна. **User ID**, **Invite code** оруулах дэлгэц нээгдэнэ.

5 **Аппад: User ID**

Онлайн банкны **Гараар** табын **Хэрэглэгчийн нэр** мөрөөс хуулсан утгыг оруулна.


6 **Аппад: Invite code**

Онлайн банкны **Гараар** табын **Түлхүүр нууц үг** мөрөөс хуулсан утгыг оруулна. Том, жижиг үсэг ялгаатай.

7 **Validate**


Validate-ийг дарна. Апп 4 оронтой PIN үүсгэх дэлгэц рүү шилжинэ.

Аппад PIN үүсгэх



1 **Аппад: PIN үүсгэх**

Аппад 4 оронтой PIN код үүсгэж, давтан оруулна. 4 ижил тоо (1111) болон дараалсан тоо (1234) оруулах боломжгүй.




2 **Аппад бүртгэгдсэн**

TDB approve service has been registered successfully. мэдэгдэл гарахад **OK** дарна. Үүний дараа онлайн банк руугаа буцаж бүртгэлээ дуусгана.

ДЭЛГЭЦ 6 / 7


Онлайн банкинд буцаж үргэлжлүүлэх



1 **Үргэлжлүүлэх**

Аппын бүртгэл дууссаны дараа онлайн банкны **Үргэлжлүүлэх**-ийг дарна.

Амжилттай бүртгэгдлээ



1 **Амжилттай бүртгэгдлээ**

Цонхонд **Төхөөрөмж амжилттай бүртгэгдлээ. Та уг төхөөрөмжөөс баталгаажуулалт хийх боломжтой боллоо.** гэж гарна. Цаашид гүйлгээ болон бусад үйлдлийг HID Approve аппаараа баталгаажуулна.

2 **Үргэлжлүүлэх**

Үргэлжлүүлэх-ийг дарахад цонх хаагдаж, HID бүртгэлийн өмнө эхлүүлсэн үйлдэл рүүгээ буцна.

Бүртгүүлэх, идэвхжүүлэх


Байгууллагын онлайн банкны эрхийг салбарт бүртгүүлж, онлайнаар идэвхжүүлнэ.

ЗАМ Нэвтрэх хуудас › Бүртгүүлэх › Бүртгэл идэвхжүүлэх

ХОЛБООТОЙ ЗААВАР Интернэт банкинд нэвтрэх · HID Approve-д бүртгүүлэх

ДЭЛГЭЦ 1/4


Бүртгүүлэх, идэвхжүүлэх сонголт



1 **Бүртгэл идэвхжүүлэх**


Салбарт бүртгүүлж, и-мэйлээр нэвтрэх нэр авсан бол сонгоно. Нэвтрэх нэр бүртгэлтэй и-мэйл хаягт, нэг удаагийн код бүртгэлтэй утасны дугаарт ирнэ.

Нэвтрэх нэр, нэг удаагийн код оруулах



1 **Нэвтрэх нэр**

И-мэйлээр ирсэн нэвтрэх нэрээ том, жижиг үсэг, доогуур зураасыг нь яг адилхан оруулна.



2 **Нэг удаагийн код**


Утсанд мессежээр ирсэн нэг удаагийн кодыг оруулна. Оруулсан код цэгээр нууцлагдаж харагдана.

3 **Идэвхжүүлэх**

Хоёр талбар бөглөгдөхөд **Идэвхжүүлэх** товч идэвхжинэ. Дарахад шинэ нууц үг үүсгэх дэлгэц нээгдэнэ.

ДЭЛГЭЦ 3 / 4

Шинэ нууц үг үүсгэх



1 **Шинэ нууц үг**


Цаашид ашиглах нууц үгээ хоёр талбарт ижил оруулна. Нууц үг 8–20 тэмдэгт, дор хаяж 1 том үсэг, 1 жижиг үсэг, 1 тоо, 1 тусгай тэмдэгт агуулна.

2 **Үргэлжлүүлэх**

Хоёр талбар бөглөгдөхөд **Үргэлжлүүлэх** товч идэвхжинэ. Дарахад бүртгэл идэвхжинэ.

ДЭЛГЭЦ 4/4

Бүртгэл амжилттай идэвхжлээ



1 Амжилттай идэвхжлээ

Таны бүртгэл амжилттай идэвхжлээ гэсэн цонх гарна. Цаашид нэвтрэх нэр, нууц үгээ ашиглан TDBOnline-д нэвтэрнэ.

2 Нэвтрэх

Нэвтрэх-ийг дарж нэвтрэх хуудас руу шилжинэ. Нэвтрэх нэр, шинэ нууц үгээрээ нэвтэрнэ.

Интернэт банкинд нэвтрэх →

Нууц үг сэргээх

Нууц үгээ мартсан эсвэл блоклогдсон үед нэвтрэх хуудаснаас шинэ нууц үг тохируулна. Хуучин системээс шилжиж ирсэн болон шинэ системийн хэрэглэгчийн алхам ялгаатай.


ХОЛБООТОЙ ЗААВАР Интернэт банкинд нэвтрэх · Нэвтрэх нэр сэргээх · Аюулгүй байдлын тохиргоо

ХУВИЛБАР 1 / 2


Хуучин системийн хэрэглэгч

ЗАМ Нэвтрэх хуудас › Нэвтэрч чадахгүй байна уу? › Нууц үг сэргээх

ДЭЛГЭЦ 1 / 6 **Нэвтэрч чадахгүй байна уу?**




1 **Нэвтэрч чадахгүй байна уу?**
Нэвтрэх хуудасны доод хэсэгт **Бүртгүүлэх**-ийн доор байрлах **Нэвтэрч чадахгүй байна уу?** холбоосыг дарна.



2 **Нууц үг сэргээх**

Гарч ирэх цонхноос **Нууц үг сэргээх**-ийг сонгоно.

ДЭЛГЭЦ 2/6 Нэвтрэх нэр оруулах




1 **Нэвтрэх нэр**

Нууц үг сэргээх хуудсанд хуучин интернэт банкинд ашиглаж байсан нэвтрэх нэрээ оруулна.

2 **Үргэлжлүүлэх**


Нэвтрэх нэр оруулсны дараа **Үргэлжлүүлэх** идэвхжинэ. Дарахад и-мэйл хаяг, зурган код оруулах талбарууд гарна.

И-мэйл хаяг, зурган код оруулах



1 **И-мэйл хаяг**

Банкинд бүртгэлтэй и-мэйл хаягаа оруулна. Баталгаажуулах код энэ хаягт илгээгдэнэ.



2 **Зурган код**


Зурган дээрх кодыг **Зурган кодыг энд оруулна уу** талбарт оруулна. Зургийн баруун талын сэргээх дүрсээр шинэ код авч болно.

3 **Үргэлжлүүлэх**

Бүх талбар бөглөгдөхөд **Үргэлжлүүлэх** идэвхжинэ. Дарахад и-мэйлээр ирсэн кодоор баталгаажуулах цонх гарна.

ДЭЛГЭЦ 4 / 6


И-мэйлээр ирсэн кодоор баталгаажуулах



1 **Код оруулах**

И-мэйлд ирсэн 6 оронтой кодыг оруулаад **Баталгаажуулах**-ыг дарна. Тоолуур дууссаны дараа шинэ код авах боломжтой.

ДЭЛГЭЦ 5 / 6 **Нууц үг амжилттай илгээгдлээ**




1 **Нууц үг илгээгдлээ**

Таны бүртгэлтэй утасны дугаарт нэг удаагийн нууц үг илгээлээ гэсэн цонх гарч, утсанд нэг удаагийн нууц үг ирнэ.

2 **Нэвтрэх**

Нэвтрэх-ийг дарж нэвтрэх хуудас руу шилжинэ.

Нэг удаагийн нууц үгээр нэвтрэх



1 **Нэвтрэх нэр**

Нэвтрэх хуудсанд нэвтрэх нэрээ оруулна.

2 **Нэг удаагийн нууц үг**

Утсанд мессежээр ирсэн нэг удаагийн нууц үгийг **Нууц үг** талбарт оруулна.


3 **Үргэлжлүүлэх**

Үргэлжлүүлэх-ийг дарж нэвтэрнэ. Цаашдын алхам **Интернэт банкинд нэвтрэх** зааврын **Хуучин системээс шилжиж буй** хэсгийн дагуу үргэлжилнэ.

Интернэт банкинд нэвтрэх →


Шинэ системийн хэрэглэгч

ДЭЛГЭЦ 1/7 Нэвтэрч чадахгүй байна уу?



1 **Нэвтэрч чадахгүй байна уу?**


Нэвтрэх хуудсанд **Үргэлжлүүлэх** болон **Бүртгүүлэх** товчийн доор байрлах **Нэвтэрч чадахгүй байна уу?** холбоосыг дарна.



2 Нууц үг сэргээх


Нэвтэрч чадахгүй байна уу цонхонд **Нууц үг сэргээх**, **Нэвтрэх нэр сэргээх** гэсэн хоёр сонголт байна. **Нууц үг сэргээх**-ийг сонгоно.

ДЭЛГЭЦ 2/7 Нэвтрэх нэр оруулах



1 Нэвтрэх нэр


Нууц үг сэргээх хуудасны **Нэвтрэх нэр** талбарт онлайн банкинд нэвтэрдэг нэрээ оруулна.



2 **Үргэлжлүүлэх**

Нэвтрэх нэрээ оруулсны дараа **Үргэлжлүүлэх** идэвхжинэ. Дарахад байгууллагын дугаар эсвэл регистрийн дугаар оруулах талбар гарна.

Байгууллагын дугаар эсвэл регистр




1 **Байгууллага**

Анхдагчаар **Регистрийн дугаар** талбар гарах тул **Байгууллагын харилцагч бол энд дарна уу**-г дарж, **Байгууллагын дугаар** талбарт байгууллагын дугаарааа оруулна.

2 **Үргэлжлүүлэх**

Нэвтрэх нэр болон дугаар бөглөгдсөний дараа **Үргэлжлүүлэх** идэвхжинэ. Дарахад баталгаажуулах суваг сонгох цонх гарна.

ДЭЛГЭЦ 4/7 **Баталгаажуулах суваг сонгох**




1 **Баталгаажуулах суваг**

Мессеж, **И-мэйл**, **HID Authenticator** сувгийн аль нэгийг сонгон баталгаажуулалт хийнэ. Утасны дугаар, и-мэйл хаяг хэсэгчлэн нууцлагдаж харагдана.

HID Approve-д бүртгүүлэх →


ДЭЛГЭЦ 5/7 **Код оруулах**



1 **Код оруулах**


Ирсэн 4 оронтой кодыг оруулахад **Баталгаажуулах** товч идэвхжинэ, дарна. Тоолуур дууссаны дараа **Шинэ код авах**-аар дахин код авч болно.

Шинэ нууц үг үүсгэх



1 **Шинэ нууц үг**

Шинэ нууц үгээ хоёр талбарт ижил оруулна. Нууц үг 8–20 тэмдэгт, дор хаяж 1 том үсэг, 1 жижиг үсэг, 1 тоо, 1 тусгай тэмдэгт агуулах ба хуучин нууц үгтэй ижил байж болохгүй.




2 **Үргэлжлүүлэх**

Хоёр талбар бөглөгдсөний дараа **Үргэлжлүүлэх** идэвхжинэ. Дарж нууц үгээ сэргээнэ.

ДЭЛГЭЦ 7 / 7

Амжилттай сэргээгдлээ



1 **Нууц үг амжилттай сэргээгдлээ**

Нууц үг амжилттай сэргээгдлээ гэсэн цонх гарна. Дараагийн удаа шинэ нууц үгээрээ нэвтэрнэ.

2 **Нэвтрэх**

Нэвтрэх-ийг дарахад нэвтрэх хуудас нээгдэнэ. Нэвтрэх нэр болон шинэ нууц үгээ оруулж нэвтэрнэ.

Интернэт банкинд нэвтрэх →


Нэвтрэх нэр сэргээх

Байгууллагын хэрэглэгч нэвтрэх нэрээ онлайнаар сэргээх боломжгүй. Нэвтрэх нэрээ мартсан бол банкны салбарт хандана.

ЗАМ Банкны салбар (онлайнаар сэргээх боломжгүй)

ХОЛБООТОЙ ЗААВАР Интернэт банкинд нэвтрэх

ДЭЛГЭЦ 1/1 Нэвтрэх нэр



1 Нэвтрэх нэр

Байгууллагын хэрэглэгч нэвтрэх нэрээ онлайнаар сэргээх боломжгүй. Нэвтрэх нэрээ мартсан тохиолдолд банкны салбараар дамжуулан шалгуулна.


Нүүр хуудастай танилцах

Нэвтэрсний дараа нээгдэх нүүр хуудасны хэсгүүд, шуурхай үйлдлүүд.

ЗАМ Нүүр хуудас

ХОЛБООТОЙ ЗААВАР Данс, үлдэгдэл харах · Мэдэгдэл, цэсээр хайх

ДЭЛГЭЦ 1/2 Нүүр хуудасны бүтэц



1 Үндсэн данс

Хуудасны дээд хэсгийн карт дээр үндсэн дансны үлдэгдэл, дугаар харагдана. Үндсэн дансаа **Тохиргоо** цэсийн **Үндсэн данс сонгох**-оос сольж болно.

2 Шилжүүлэг хийх

Үндсэн дансны картын баруун дээд буланд байрлах **Шилжүүлэг хийх** товчоор шилжүүлгийн хуудсыг шууд нээнэ.

Дотоод шилжүүлэг хийх →

3 Данс хайх

Картын доод мөрийн **Данс хайх**-ыг дарахад системийн шинэчлэлтээр өөрчлөгдсөн дансны хуучин, шинэ дугаарууд харагдана.

4 Дансны жагсаалт

Картын доод мөрийн **Дансны жагсаалт**-ыг дарахад байгууллагын бүх данс жагсаалтаар нээгдэнэ.

Данс, үлдэгдэл харах →

5 Хуулга татах

Картын доод мөрийн **Хуулга татах**-ыг дарахад дансны хуулгын хуудас нээгдэж, бүрэн хуулгаа эндээс авна.

6 Дансны хуулга

Үндсэн дансны сүүлийн гүйлгээнүүд **Огноо**, **Харьцсан данс/IBAN**, **Гүйлгээний утга**, **Дүн** баганаар харагдана. **Бүгд**-ээр бүх хуулгыг нээнэ.

7 Гүйлгээний загвар

Гүйлгээний загвар хэсэгт хадгалсан загварууд нэр, дүнтэйгээ харагдана. Загвар дээр дарж шууд шилжүүлэх бөгөөд бүх загвараа **Бүгд**-ээр харна.

Гүйлгээний загвар →

8 Гүйлгээний хүсэлт

Зөвшөөрөх гүйлгээ-ний тоо таны зөвшөөрөл хүлээж буй гүйлгээг, **Илгээсэн гүйлгээ**-ний тоо таны илгээсэн хүсэлтийг заана. Мөр бүр дээр дарж жагсаалтыг нь нээнэ.

Илгээсэн хүсэлт →

9 Ханшийн самбар

Бэлэн бус ханш, **Бэлэн ханш** гэсэн хоёр табаар валют бүрийн **Албан**, **Авах**, **Зарах** ханшийг харна.


10 Холболтын хугацаа

Баруун дээд буланд сессийн үлдсэн хугацаа тоологдоно. 2 минут үлдэхэд гарах цонхонд **Сунгах**-ыг дарж үргэлжлүүлэн ажиллана.

11 Мэдэгдэл

Баруун дээд буланд байрлах хонхны дүрс дээр үншаагүй мэдэгдлийн тоо улаанаар гарна. Дарж мэдэгдлүүдээ харна.

ДЭЛГЭЦ 2/2 **Данс хайх**



1 Хайх

Данс хайх цонхны дээд хэсгийн **Дансны дугаараар хайх...** талбарт дансны дугаараа бичиж хайна.

2 Хуучин → Шинэ

Харилцах данс хэсэгт данс бүрийн IBAN дугаар, доор нь зураастай **Хуучин** дугаар, сумны баруун талд **Шинэ** дугаар харагдана.

3 Хуулах

IBAN дугаарын баруун талын хуулах дүрсийг дарахад дугаар санах ойд хуулагдана.

Мэдэгдэл, цэсээр хайх


Аюулгүй байдлын болон бусад мэдэгдлээ харах, хэрэгтэй цэсээ нэрээр нь хайх.

ЗАМ Нүүр хуудас › Мэдэгдэл (хонх)

ЭСВЭЛ Хажуугийн цэс › Хайх

ХОЛБООТОЙ ЗААВАР Нүүр хуудастай танилцах


ДЭЛГЭЦ 1/2 Мэдэгдлийн хонх



1 Хонх

Баруун дээд буланд байрлах хонхны дүрсийг дарна. Уншаагүй мэдэгдлийн тоо улаанаар харагдана.

Цэсээр хайх



1 **Хайх**

Хажуугийн цэсний дээд хэсгийн **Хайх...** талбарт цэсний нэрийн эхний хэдэн үсгийг бичнэ.

2 **Илэрц**

Тохирох цэсүүд тайлбартайгаа гарна. Жишээ нь **шилж** гэж бичихэд **Дотоод шилжүүлэг**, **Гадаад шилжүүлэг** зэрэг гарах бөгөөд дээр нь дарж шууд очно.


Данс, үлдэгдэл харах

Байгууллагын бүх дансаа жагсаалтаар харах, дэлгэрэнгүй, үлдэгдэл, битүүмжилсэн дүнг шалгах.

ЗАМ Данс › Дансны жагсаалт

ХОЛБООТОЙ ЗААВАР Дансны хуулга авах · Дансны тодорхойлолт авах · Дансны тохиргоо

ДЭЛГЭЦ 1/2 Дансны жагсаалт



1 Дансны төрөл

Бүх данс, Харилцах, Хугацаагүй хадгаламж, Хугацаатай хадгаламж табаар шүүнэ. Таб бүрт дансны тоо харагдах ба доорх хүснэгтэд сонгосон төрлийн данснууд үлдэнэ.


2 Данс

Мөр бүр нэг данс бөгөөд **Валютын төрөл**, **Дансны дугаар**, **Дансны нэршил**, **Үлдэгдэл** баганаар харагдана. Үлдэгдэл тухайн дансны валютаар гарна.

3 Дэлгэрэнгүй

Мөрийн төгсгөлийн **Дэлгэрэнгүй** дээр дарахад дансны боломжит болон нийт үлдэгдэл, битүүмжилсэн дүн, сүүлийн гүйлгээнүүд нэг хуудсанд нээгдэнэ.

Дансны дэлгэрэнгүй



1 Данс сонгох

Дансны дугаарын хажуугийн сумыг дарж өөр данс сонгоно. Үлдэгдэл, битүүмжилсэн дүн, хуулга сонгосон дансных болж шинэчлэгдэнэ.

2 Үлдэгдэл


Боломжит үлдэгдэл ба нийт үлдэгдэл харагдана. Боломжит үлдэгдэл нь нийт үлдэгдлээс битүүмжилсэн дүнг хассан, зарцуулах боломжтой дүн юм.

3 Битүүмжилсэн дүн

Нийт битүүмжилсэн гүйлгээний дүн харагдана. Энэ нь дансанд байгаа ч одоогоор зарцуулах боломжгүй мөнгө юм.


4 Дэлгэрэнгүй

Дарахад битүүмж бүрийг тусад нь харуулсан цонх нээгдэж, нийт битүүмжилсэн дүн юунаас бүрдэж байгааг харна.



5 Битүүмжийн жагсаалт

Цонхонд битүүмж бүр **Огноо**, **Шалтгаан**, **Дүн** баганаар түсдаа мөрөөр жагсана. Баруун дээд булангийн X тэмдгээр цонхыг хаана.



6 Дансны хуулга

Тухайн дансны сүүлийн гүйлгээнүүд **Огноо**, **Харьцсан данс/IBAN**, **Гүйлгээний утга**, **Дүн** баганаар харагдана. Илүү урт хугацааны хуулга харах бол **Бүгд**-ийг дарна.

Дансны хуулга авах


Сонгосон хугацааны дансны хуулгыг харах, орлого зарлагаар шүүх, татах.

ЗАМ Нүүр хуудас › Хуулга татах

ЭСВЭЛ Данс › Дансны жагсаалт › Дэлгэрэнгүй › Дансны хуулга татах

ХОЛБООТОЙ ЗААВАР Данс, үлдэгдэл харах

ДЭЛГЭЦ 1/1 Данс, хугацаа сонгох



1 Данс
Дансны дугаарын хажуугийн сумыг дарж хуулга гаргах дансаа жагсаалтаас сонгоно.

2 Огноо
Эхлэх огноо, **Дуусах огноо** талбарын календарийн дүрсийг дарж өдрөө сонгоно, эсвэл **7 хоног**, **1 сар**, **3 сар**-ын аль нэгийг дарна.

3 Хуулгын төрөл
Хуулгын төрөл талбарыг дарж Бүгд, Орлого, Зарлагын аль нэгийг сонгоно. Анхдагчаар **Бүгд** сонгогдсон байдаг.

4 Хуулга татах
Хуулга татах-ыг дарахад хуулга банкинд бүртгэлтэй и-мэйл хаяг руу илгээгдэнэ.

5 Хуулга
Шүүсэн гүйлгээнүүд **Дансны хуулга** хэсэгт **Огноо**, **Харьцсан данс/IBAN**, **Гүйлгээний утга**, **Дүн** баганаар жагсана.


Дансны тодорхойлолт авах

Дансны тодорхойлолт, үлдэгдлийн баталгаа зэрэг албан бичгийг онлайнаар авах.

ЗАМ Данс › Дансны тодорхойлолт


ХОЛБООТОЙ ЗААВАР Данс, үлдэгдэл харах · Дансны хуулга авах

ДЭЛГЭЦ 1/2 **Тодорхойлолтын төрөл**



1 Төрөл сонгох


Данс → Дансны тодорхойлолт цэсэнд **Төрөл сонгох**-ыг дарна. Төрлөө сонгосны дараа данс, хэл, хүлээн авагчийн талбарууд гарч ирнэ.



2 **Төрлүүд**

Дансны тодорхойлолт (үлдэгдэлтэй, үлдэгдэлгүй), үлдэгдлийн баталгаа, ЭСЯ-нд зориулсан, зээлийн үлдэгдэл, кредит данс, картын данс зэрэг төрлөөс хүлээн авах байгууллагын шаардсаныг сонгоно.

Маягтаа бөглөх



1 Төрөл

Төрөл сонгох талбарт өмнөх алхамд сонгосон төрөл харагдана.

2 Данс

Тодорхойлолт гаргах дансаа сонгоно. Талбарын баруун талд сонгосон дансны **Боломжит үлдэгдэл** харагдана.

3 Хэл

Хэл сонгох талбарыг дарж Монгол эсвэл Англи хэлийг сонгоно.

4 Хэнд

Хэнд талбарт тодорхойлолтыг хүргүүлэх байгууллагын албан ёсны нэрийг бичнэ. Энэ нэр тодорхойлолтод хүлээн авагчаар гарна.

5 Тодорхойлолт авах

Төрөл, данс, хэл, хүлээн авагчийн нэрээ шалгаад **Тодорхойлолт авах**-ыг дарна.

Дотоод шилжүүлэг хийх

Бусдын данс руу (банк дотор, банк хооронд), өөрийн данс хооронд, утасны дугаараар шилжүүлэх.


ХОЛБООТОЙ ЗААВАР IBAN лавлах · Гүйлгээний загвар · Багц шилжүүлэг

ХУВИЛБАР 1 / 3

Бусдын данс руу

ЗАМ Шилжүүлэг › Дотоод шилжүүлэг › Бусдын данс

ДЭЛГЭЦ 1 / 4 **Гүйлгээ хийх**



1 Зарлага гарах данс

ХАРИЛЦАХ ДАНС талбарт мөнгө гарах дансаа сонгоно. Баруун талд нь **Боломжит үлдэгдэл** харагдах ба өөр данс сонгох бол сумыг дарж солино.

2 Бусдын данс


Бусдын данс таб сонгогдсон байна. Энэ таб өөр хүн, байгууллагын данс руу шилжүүлэхэд зориулагдсан бөгөөд доор **IBAN**, **Дансны нэр** талбарууд гарна.

3 IBAN

IBAN талбар MN үсгээр эхэлдэг тул хүлээн авагчийн IBAN-ын үлдсэн цифрүүдийг оруулна. Эсвэл дээд талын **IBAN лавлах**-аас хуулна.

IBAN лавлах →

Хүлээн авагч




1 **IBAN**

IBAN талбарт MN угтвартайгаар оруулсан дугаар харагдана.

2 **Хүлээн авагч**

Хүлээн авагчийн банкны лого, нэр болон дансны эзэмшигчийн нэр автоматаар гарна. Нэр таны шилжүүлэх гэж буй хүн, байгууллагатай таарч байгааг шалгана.

Дүн, гүйлгээний утга



1 Шилжүүлэх дүн

Шилжүүлэх дүн талбарт зарлага гарах дансны валютаар дүнгээ оруулна. Валют нь талбарын баруун талд харагдана.


2 Гүйлгээний утга

Гүйлгээний утга-д төлбөрийн зориулалт, нэхэмжлэх, гэрээний дугаар зэргийг тодорхой бичнэ. Утга хүлээн авагчийн хуулгад харагдана.

3 Үргэлжлүүлэх

Бүх талбарыг бөглөөд **Үргэлжлүүлэх**-ийг дарна. Бүх мэдээллийг нэгтгэсэн **Гүйлгээ баталгаажуулах** дэлгэц нээгдэнэ.

Гүйлгээ баталгаажуулах



1 Мэдээллээ шалгах

Зарлага гарах данс, **Шилжүүлэх дүн**, **Хүлээн авах дүн**, **Гүйлгээний утга**, хүлээн авагчийн банк, **Дансны нэр**, **Гүйлгээний шимтгэл**-ийг нэг дор шалгана.

2 Шилжүүлэх


Мэдээллээ шалгаад **Шилжүүлэх**-ийг дарна. Байгууллагын зөвшөөрлийн дараалал тохируулсан бол гүйлгээ **Гүйлгээний хүсэлт** болж зөвшөөрөл хүлээнэ.

ХУВИЛБАР 2/3

Өөрийн данс хооронд

ЗАМ Шилжүүлэг › Дотоод шилжүүлэг › Өөрийн данс

ДЭЛГЭЦ 1/3 **Өөрийн данс**




1 **Өөрийн данс**

Өөрийн данс табыг сонгоно. IBAN, нэр бичих талбарын оронд **Данс сонгох** жагсаалт гарна.

2 **Данс сонгох**


Данс сонгох талбарыг дарж хүлээн авах дансаа жагсаалтаас сонгоно. Данс сонгогдох хүртэл **Үргэлжлүүлэх** товч идэвхгүй байна.



3 **Өөрийн данснууд**

Жагсаалтад өөрийн бусад дансны нэршил, дугаар, **Боломжит үлдэгдэл** харагдана.

Дүн, гүйлгээний утга



1 Хүлээн авах данс

Хүлээн авагч хэсэгт сонгосон дансны нэршил, дугаар, үлдэгдэл харагдана. Өөр данс сонгох бол сумыг дарж солино.

2 Шилжүүлэх дүн

Шилжүүлэх дүн талбарт дүнгээ оруулна. Валют нь талбарын баруун талд харагдана.


3 Гүйлгээний утга

Гүйлгээний утгыг бичнэ. Утга хоёр дансны хуулгад харагдах тул шилжүүлгээ танихуйц зориулалтыг нь бичнэ.

4 Үргэлжлүүлэх

Үргэлжлүүлэх-ийг дарахад бүх мэдээллийг нэг дор харуулсан **Гүйлгээ баталгаажуулах** дэлгэц нээгдэнэ.

Баталгаажуулах



1 **Мэдээллээ шалгах**

Зарлага гарах дансны **IBAN**, **Дансны үлдэгдэл**, **Шилжүүлэх дүн**, **Гүйлгээний утга**, хүлээн авах дансны **Дансны нэр**-ийг шалгана.

2 **Шилжүүлэх**


Мэдээллээ шалгаад **Шилжүүлэх**-ийг дарна.

ХУВИЛБАР 3/3

Утасны дугаараар

ЗАМ Шилжүүлэг › Дотоод шилжүүлэг › Бусдын данс › Утасны дугаар

ДЭЛГЭЦ 1/1 Утасны дугаараар хайх



1 **Утасны дугаар**

Бусдын данс таб дээр **Хүлээн авагч** хэсгийн баруун талын **Утасны дугаар** унтраалгыг асаана. IBAN талбар **Утасны дугаар** талбараар солигдоно.

2 **Дугаар**

Хүлээн авагчийн дансанд холбогдсон утасны дугаарыг оруулна.

3 **Дансны нэр**

Дугаарт холбогдсон данс, эзэмшигчийн нэр **Дансны нэр** талбарт автоматаар гарна. Нэр хүлээн авагчтай таарч байгааг шалгана.

IBAN лавлах

Хүлээн авагчийн IBAN-ыг дансны дугаар эсвэл орлох дугаараар нь олж, шилжүүлгийн маягтад бөглөх.


ХОЛБООТОЙ ЗААВАР Дотоод шилжүүлэг хийх

ХУВИЛБАР 1 / 2

Дансны дугаараар

ЗАМ Шилжүүлэг › Дотоод шилжүүлэг › IBAN лавлах

ДЭЛГЭЦ 1 / 4 **IBAN лавлагаа нээх**



1 IBAN лавлах


Шилжүүлэг → **Дотоод шилжүүлэг** хуудасны баруун дээд хэсгийн **IBAN лавлах**-ыг дарна.

2 Дансны дугаар таб

IBAN лавлагаа цонх **Дансны дугаар** таб сонгогдсон байдлаар нээгдэнэ.

ДЭЛГЭЦ 2/4

Дансны дугаараар хайх




1 **Дансны дугаар**

Хүлээн авагчийн дансны дугаарыг MN угтваргүй, зөвхөн цифрээр нь оруулна.

2 **Хайх**

Дугаар оруулахад **Хайх** товч идэвхжинэ. Дарахад хүлээн авагчийн IBAN, дансны нэр гарна.

Үр дүн



1 **IBAN, дансны нэр**


Олдсон IBAN, дансны нэр харагдах тул нэрийг шалгана. Баруун талын хуулах дүрсээр IBAN-ыг санах ойд хуулж болно.

2 **Үргэлжлүүлэх**

Үргэлжлүүлэх-ийг дарахад цонх хаагдаж, олдсон IBAN шилжүүлгийн маягтад бөглөгдөнө.

ДЭЛГЭЦ 4/4

Шилжүүлгийн маягтад бөглөгдөнө



1 **IBAN**

Олдсон IBAN **IBAN** талбарт автоматаар бөглөгдсөн байна.

2 **Хүлээн авагч**

Хүлээн авагчийн банк, дансны нэр гарна. Нэр таны шилжүүлэх гэж буй хүлээн авагчтай таарч байгааг шалгана.

3 **Гүйлгээний мэдээлэл**

Дүн, гүйлгээний утгаа оруулж шилжүүлгээ үргэлжлүүлнэ.


Дотоод шилжүүлэг хийх →

ХУВИЛБАР 2/2

Орлох дугаараар

ЗАМ Шилжүүлэг › Дотоод шилжүүлэг › IBAN лавлах

ДЭЛГЭЦ 1/1 Орлох дугаараар хайх



1 **Орлох дугаар таб**

Орлох дугаар табыг сонгоно. Орлох дугаар нь дансны дугаарын оронд ашигладаг, Дансны нэгдсэн санд бүртгэлтэй утас эсвэл и-мэйл юм.

2 **Утас / И-мэйл**

Утас / И-Мэйл талбарт Дансны нэгдсэн санд бүртгэлтэй утас эсвэл и-мэйлийн аль нэгийг оруулна.

3 **Хайх**

Хайх-ыг дарна. Хүлээн авагчийн IBAN, дансны нэр гарах бөгөөд нэрийг шалгана.


Гадаад руу шилжүүлэх (SWIFT)

Гадаад улсын банкны данс руу SWIFT-ээр мөнгө шилжүүлэх.

ЗАМ Шилжүүлэг › Гадаад шилжүүлэг


ХОЛБООТОЙ ЗААВАР Гадаад гүйлгээ лавлах · Арилжааны хүсэлт

ДЭЛГЭЦ 1/9 **Улс, валют, дүн**




1 **Шилжүүлэх улс**

Шилжүүлэх улс талбарыг дарж жагсаалтаас улсаа сонгоно. Улсын нэр эсвэл кодоор хайж болно.




2 Улсын жагсаалт

Жагсаалтын дээд талын хайлтын мөрөөр улсын нэр эсвэл кодоор хайна. Хүлээн авагчийн иргэншил биш, банк нь байрлаж буй улсыг сонгоно.




3 Валют

Улсын талбарын баруун талын валютын сонголтоос шилжүүлэх валютаа сонгоно. Анхдагчаар **USD** сонгогдсон байдаг тул хүлээн авагчийн валют өөр бол сольж сонгоно.



4 Валютын жагсаалт

USD, AUD, CAD, CHF, CNY, EUR, GBP, HKD гэх мэт валютаас хүлээн авагчийн дансны валюттай тохирохыг сонгоно.




5 Шилжүүлэх дүн

Хүлээн авагчид очих дүнг сонгосон валютаар нь оруулна. Данснаас хасагдах төгрөгийн дүн, ханш дараагийн алхамд харагдана.

6 Үргэлжлүүлэх

Улс, валют, дүн бөглөгдсөний дараа товч идэвхжинэ. Дарахад гүйлгээний лимитийн мэдээлэл гарч болно.


ДЭЛГЭЦ 2/9 Гүйлгээний лимит



1 **Үргэлжлүүлэх**

Лимитийн мэдээллийн цонхонд дүн тохиромжтой бол дарж шилжүүлгийн төрөл сонгох алхам руу шилжинэ.


ДЭЛГЭЦ 3/9 Шилжүүлгийн төрөл



1 **Swift transfer**

Банкны шимтгэл, дамжуулагч банкны шимтгэл (заавал биш), шилжих хугацааг шалгаад сонгоно. Энэ төрөлд хүлээн авагч банкны SWIFT/BIC код шаардлагатай.

1/6 Шилжүүлэгчийн мэдээлэл



1 Зарлага гарах данс

Мөнгө гарах дансаа сонгоно. Дансны хажууд **Боломжит үлдэгдэл** харагдах ба шилжүүлэгчийн нэр, регистр, утас, хаяг байгууллагын бүртгэлээс автоматаар бөглөгдөнө.

2 Байгууллагын мэдээлэл

Байгууллагын нэр, регистр, утас, хаяг автоматаар гарна. Нэр, регистрийн дугаараас бусдыг засаж болно.

3 Дүн

Шилжүүлэх дүн сонгосон валютаар, **Данснаас хасагдах дүн** дансны валютаар, доор нь хэрэглэсэн ханш харагдана. Шимтгэл 5-р алхамд нэмэгдэнэ.


4 Үргэлжлүүлэх

Шилжүүлэгчийн мэдээлэл, дүнгээ шалгаад дарж хүлээн авагчийн банкны мэдээллийн алхам руу шилжинэ.

5 SWIFT гүйлгээ

Баруун талын **SWIFT гүйлгээ** хэсгээс өмнөх гүйлгээ эсвэл загвараа сонговол бүх алхам бөглөгдөнө. Бөглөгдсөн мэдээллийг алхам бүрт шалгаж, шаардлагатай бол засна.

2/6 Хүлээн авагчийн банк




1 **SWIFT кодоор**

Унтраалга асаалттай үед банкаа SWIFT код эсвэл нэрээр хайж, банкны нэр, хаягийг автоматаар бөглүүлнэ. Банкны мэдээллийг гараар оруулах бол унтраана.


2 **SWIFT код**

Хүлээн авагчаас авсан 8 эсвэл 11 оронтой кодыг оруулаад **Хайх**-ыг дарна. Банкны төв салбар руу илгээх бол кодын араас XXX нэмж бичигдсэн эхний мөрийг сонгоно.




3 **Банк хайх**

Хүлээн авагч банк сонгох цонх нээгдэж, **SWIFT код** эсвэл **Банкны нэр** табаар банкаа хайна.




4 **Банк сонгох**

Илэрц бүрт банкны нэр, бүтэн SWIFT код, хот харагдана. Хүлээн авагчийн өгсөн кодтой бүрэн таарах банк, салбарыг сонгоно.




5 **Банкны мэдээлэл**

Сонгосон банкны **Банкны нэр**, **Банкны хаяг** талбар автоматаар бөглөгдөнө. Хүлээн авагч тусгай код өгсөн бол **Банкны код / Бик код** талбарт нэмж оруулна.



6 Дамжуулагч банк


Хүлээн авагч дамжуулагч банк зааж өгсөн бол **Дамжуулах банк (хэрэв байгаа бол)** унтраалгыг асааж мэдээллийг нь оруулна. Заагаагүй бол хоосон орхино.



7 Үргэлжлүүлэх

Банкны мэдээлэл бөглөгдсөний дараа товч идэвхжинэ. Дарж хүлээн авагчийн мэдээллийн алхам руу шилжинэ.

3/6 Хүлээн авагч



1 **Данс эсвэл IBAN**

Улсаас хамаарч дансны дугаар эсвэл IBAN оруулна. IBAN хэрэглэдэг улсад (жишээ нь Европын орнууд) IBAN-ыг, бусад улсад дансны дугаарыг бичнэ.

2 **Хүлээн авагчийн нэр**

Хүлээн авагчийн нэрийг банкинд бүртгэлтэй ёсоор нь латинаар, товчлохгүй бичнэ. Хүлээн авагч байгууллага бол хуулийн этгээдийн бүтэн нэрийг оруулна.


3 **Хүлээн авагчийн хаяг**

Хаягийг бүртгэлтэй ёсоор нь товчлохгүй бичнэ. Гудамж, байрны дугаар, шуудангийн код, хотыг бүрэн оруулна.

4 **Үргэлжлүүлэх**

Хүлээн авагчийн данс, нэр, хаягаа шалгаад дарж төлбөрийн зориулалтын алхам руу шилжинэ.

4/6 Төлбөрийн зориулалт



1 **Төлбөрийн зориулалт**


Юуны төлбөр болохыг англиар, товчлолгүй, 140 тэмдэгт хүртэл бичнэ. Жишээ нь гэрээ эсвэл нэхэмжлэхийн дугаарыг дурдана.

2 **Файл хуулах**

Тасархай хүрээтэй хэсгийг дарж нэхэмжлэх, гэрээгээ хавсаргана. PDF, JPG, PNG, 20MB хүртэл файл хавсаргаж болох ба заавал биш.


3 **Үндсэн зориулалт**

Гүйлгээний үндсэн зориулалт сонгох талбарыг дарж жагсаалтаас сонгоно. Сонгосон утгаас хамаарч дэд зориулалтын жагсаалт өөрчлөгдөнө.




4 Үндсэн зориулалтууд

Payment for goods, Others, Travelers' expenses, Payment for services гэх мэт сонголт бий. Бараа худалдан авбал **Payment for goods**, ажил үйлчилгээний төлбөр бол **Payment for services**, тохирохгүй бол **Others**-ыг сонгоно.




5 Дэд зориулалт

Гүйлгээний дэд зориулалт сонгох талбар үндсэн зориулалт сонгосны дараа идэвхжинэ. Үндсэн зориулалтад тохирохыг сонгоно.



6 Дэд зориулалтууд


Жишээ нь Payment for services-ийн доор Freight transport, Insurance premium, Construction services, **Passenger transport**, **Other transport** зэрэг сонголт бий. Төлбөрийн зориулалттай хамгийн ойрхоныг сонгоно.



7 Үргэлжлүүлэх


Төлбөрийн зориулалт, үндсэн болон дэд зориулалтаа бөглөөд дарж шимтгэлийн алхам руу шилжинэ. Файл хавсаргах заавал биш.

5/6 Шимтгэл




1 Шимтгэлийн төрөл

Шимтгэлийн төрөл талбарыг дарж шимтгэлийг хэн хариуцахыг сонгоно. Төрөл сонгосны дараа шимтгэлийн задаргаа, нийт дүн доор гарна.



2 Төрлүүд

Бүх банкны шимтгэлийг шилжүүлэгч хариуцвал хүлээн авагчид дүн бүтнээр очих зорилготой. Дамжуулагч банкны шимтгэлийг хариуцахгүй бол тэр шимтгэл шилжүүлж буй дүнгээс хасагдаж болно.



3 Шилжүүлэх дүн

Хүлээн авагч руу илгээх дүн валютаар харагдана. Энэ нь 1-р алхамд оруулсан дүнтэй ижил байна.

4 Шимтгэлүүд

Банкны, дамжуулагч банкны, интернэт банкны шимтгэл тус бүр тусдаа мөрөөр төгрөгөөр харагдана. Дамжуулагч банкны шимтгэл сонгосон шимтгэлийн төрлөөс хамаарч өөрчлөгдөнө.

5 Нийт шимтгэл, хугацаа

Нийт шимтгэл нь дээрх шимтгэлүүдийн нийлбэр, **Шилжүүлэх хугацаа** нь мөнгө хүлээн авагчид очих хүртэлх ажлын өдрийн тоо юм.


6 Данснаас хасагдах нийт дүн

Шилжүүлэх дүнгийн төгрөгийн дүн дээр нийт шимтгэлийг нэмсэн дүн харагдана. Энэ дүн дансны үлдэгдэлд хүрэлцэх эсэхийг шалгана.

7 Үргэлжлүүлэх

Шимтгэл, нийт дүнгээ шалгаад дарж нэгтгэл дэлгэц рүү шилжинэ. Энэ үед гүйлгээ хараахан хийгдээгүй байна.

6/6 Нэгтгэл




1 **Шилжүүлэгч**

Шилжүүлэгчийн данс, нэр, регистр, утас, хаяг харагдана. Энэ мэдээлэл 1-р алхамаас ирэх тул засах бол **Буцах**-аар тухайн алхам руу очно.

2 **Шилжүүлэг**

Шилжүүлэх дүн валютаар, шимтгэлүүд болон **Данснаас хасагдах нийт дүн** төгрөгөөр харагдана.



3 Хүлээн авагч

Доош гүйлгэхэд хүлээн авагчийн данс эсвэл IBAN, нэр, хаяг харагдана. Данс, IBAN-ыг нэхэмжлэх, гэрээнд заасантай тулгаж шалгана.

4 Хүлээн авагчийн банк

Банк байрших улс, **Хүлээн авагч банкны SWIFT**, банкны нэр, хаяг харагдана.

5 Зориулалт

4-р алхамд оруулсан төлбөрийн, үндсэн, дэд зориулалт харагдана.

6 Гүйлгээ хийх

Бүх мэдээллээ шалгаад **Гүйлгээ хийх**-ийг дарна. Гарах цонхны мэдээллийг уншаад **Зөвшөөрч гүйлгээ хийх**-ийг дарна.


Гадаад гүйлгээ лавлах

Илгээсэн SWIFT, Visa Direct гүйлгээний төлөв, явцыг шалгах.

ЗАМ Шилжүүлэг › Гадаад гүйлгээ лавлах

ХОЛБООТОЙ ЗААВАР Гадаад руу шилжүүлэх (SWIFT)

ДЭЛГЭЦ 1/1 Гүйлгээгээ хайх



1 Данс

Данс сонгох талбарын сумыг дарж гадаад гүйлгээ хийсэн дансаа сонгоно. Жагсаалтад зөвхөн тэр данснаас хийгдсэн гүйлгээ гарна.

2 Огноо

Эхлэх огноо, **Дуусах огноо** талбарын календарийн дүрсийг дарж хайх хугацаагаа сонгоно.

3 Хурдан сонголт

7 хоног, **1 сар**, **3 сар**-ын аль нэгийг дарахад өнөөдрөөс тооцож огноо автоматаар бөглөгдөнө.

4 Төрөл

Талбарыг дарж гүйлгээний төрлөөр шүүнэ. Анхдагчаар **Swift** сонгогдсон байна.

5 Хайлт

Хайлтын талбарт гүйлгээний утга, дүн эсвэл хүлээн авагчийн нэрийг бичээд томруулагч шилний дүрсийг дарна.

6 Жагсаалт

Жагсаалтад төрөл, гүйлгээний мэдээлэл, данс, огноо, дүн харагдана. Мөрийн төгсгөлийн сумыг дарж гүйлгээний дэлгэрэнгүй, төлвийг харна.


Тогтмол шилжүүлэг

Давтагдах шилжүүлгээ харах, бүртгэх.

ЗАМ Шилжүүлэг › Тогтмол шилжүүлэг

ХОЛБООТОЙ ЗААВАР Дотоод шилжүүлэг хийх · Гүйлгээний загвар

ДЭЛГЭЦ 1/1 Тогтмол шилжүүлгийн жагсаалт



1 Бүртгэл

Тогтмол шилжүүлгийн жагсаалтаас данс, хугацаа, гүйлгээний дүнг харна. Шинэ тогтмол шилжүүлэг бүртгэх бол баруун дээд хэсгийн “Тогтмол шилжүүлэг бүртгэх” товчийг дарна.

2 Төлөв

“Идэвхтэй” төлөвтэй бол тогтмол шилжүүлэг ажиллаж байгааг илэрхийлнэ.

3 Устгах

Тогтмол шилжүүлгийг устгах бол хогийн савны дүрс дээр дарна. Устгасны дараа тухайн тогтмол шилжүүлэг жагсаалтаас хасагдана.


Гүйлгээний загвар

Байнга шилжүүлдэг хүлээн авагчаа загвар болгон хадгалах.

ЗАМ Шилжүүлэг › Гүйлгээний загвар

ХОЛБООТОЙ ЗААВАР Дотоод шилжүүлэг хийх · Тогтмол шилжүүлэг

ДЭЛГЭЦ 1/2 Загварын жагсаалт



1 Загвар

Загвар бүрийн картад загварын нэр, **Хүлээн авагч**, **Гүйлгээний төрөл**, **IBAN**, **Хүлээн авагчийн банк** харагдана. Карт дээр дарахад хүлээн авагчийн мэдээлэл бөглөгдөх тул дүн, утгаа оруулаад үргэлжлүүлнэ.


3 Загвар нэмэх

Хуудасны баруун дээд талын **Гүйлгээний загвар нэмэх**-ийг дарахад загвар бүртгэх маягт нээгдэнэ.

2 Устгах

Хэрэгцээгүй болсон загварыг карт дээрх улаан хогийн савны дүрсийг дарж устгана.

Загвар нэмэх



1 Зарлага гарах данс

ХАРИЛЦАХ ДАНС талбарын сумыг дарж загвараар мөнгө гарах дансаа сонгоно. Баруун талд нь **Боломжит үлдэгдэл** харагдана.

2 Загварын нэр

Загварын нэр талбарт танихад хялбар нэр өгнө. Энэ нэр загварын жагсаалтад картын гарчиг болж харагдана.

3 Бүсдын / Өөрийн данс

Бүсдын данс сонговол **IBAN**, **Дансны нэр** талбар, **Өөрийн данс** сонговол дансаа сонгох жагсаалт гарна. Бүсдын данс дээр **Утасны дугаар** унтраалгаар утасны дугаараар бүртгэж болно.

4 Хүлээн авагч

Бүсдын данс бол IBAN оруулахад **Дансны нэр** автоматаар гарна. Өөрийн данс бол жагсаалтаас дансаа сонгоно.

5 Хадгалах

Дүн, утгаа оруулаад дарна. Хадгалсан загвар **Гүйлгээний загвар** жагсаалт болон шилжүүлгийн хуудасны баруун талын хэсэгт карт болж харагдана.

Багц шилжүүлэг

Олон данс руу нэг файлаар нэгэн зэрэг шилжүүлэх. Цалин, энгийн, MT101, UFF багц гүйлгээ.


ХОЛБООТОЙ ЗААВАР Илгээсэн хүсэлт · Гүйлгээний түүх

ХУВИЛБАР 1 / 3

Багц гүйлгээ хийх

ЗАМ Шилжүүлэг › Багц шилжүүлэг

ДЭЛГЭЦ 1 / 2 **Багц гүйлгээ эхлүүлэх**




1 Табууд
Хуудас нээгдэхэд шинэ гүйлгээ хийх таб идэвхтэй байна. Бусад табаас оруулсан файлын түүх, задарсан багц гүйлгээ болон гүйлгээний түүхийг харна.

2 Банкны код
Файлд оруулах банкны кодыг хүснэгтээс харна. Файл дахь банкны код хүснэгтийн “Банкны код”-той ижил байна.


3 Үргэлжлүүлэх
Мэдээлэлтэй танилцсаны дараа “Үргэлжлүүлэх” товчийг дарна. Дараагийн дэлгэцэд багц гүйлгээний төрлөө сонгож, файлаа оруулна.

ДЭЛГЭЦ 2/2 **Файл оруулах**




1 **Багц гүйлгээний төрөл**

“Багц гүйлгээний төрөл” талбараас төрлөө сонгоно. Сонгосны дараа тухайн төрөлд тохирох Excel загвар файл татах товч гарах тул файлаа энэ загвараар бэлдэнэ.



2 **Төрлүүд**

Энгийн, Цалингийн, MT101, UFF төрлөөс сонгоно. Цалингийн гүйлгээг Цалингийн багц гүйлгээ төрлөөр, цалингийн түр данс ашиглан хийнэ.



3 **Файл хайх**

“Файл хайх” товчийг дарж 20MB-аас ихгүй xls эсвэл txt файлаа сонгоно. Файл бэлдээгүй бол сонгосон төрөлд тохирох загварыг татаж, мэдээллээ оруулна.

4 **Багц гүйлгээний утга**

“Багц гүйлгээний утга” талбарт файлын утгыг бичнэ. Энэ нь гүйлгээ тус бүрийн утга биш.


5 **Үргэлжлүүлэх**

Файлаа оруулж, утгаа бичсний дараа “Үргэлжлүүлэх” товчийг дарна.

Түүх, жагсаалт


ЗАМ Шилжүүлэг › Багц шилжүүлэг

ДЭЛГЭЦ 1/3 Оруулсан файлын түүх



1 Оруулсан файлын түүх


Багц шилжүүлэг хуудасны «Оруулсан файлын түүх» табыг сонгоно. Хүснэгтэд огноо, илгээгчийн нэр, багц гүйлгээний төрөл, оруулсан файл, төлөв харагдана.



2 **Файлууд**


Амжилттай хуулагдсан файл «Задалж байна» төлөвтэй харагдана. Задалж дууссан файл нийт дүнгээрээ барилт хийгдэж «Багц гүйлгээний жагсаалт» руу автоматаар орно.

ДЭЛГЭЦ 2/3 Багц гүйлгээний жагсаалт



1 **Багцууд**


Багц огноо, утга, төлөвийн хамт «Хүлээгдэж байна» төлөвтэй орж ирнэ. Гүйлгээ эхэлмэгц төлөв нь «Гүйлгээ хийгдэж байна» болно.



2 **Дэлгэрэнгүй**

Багц доторх гүйлгээ бүрийн шилжүүлэх данс, хүлээн авах данс, дансны нэр, дүн, төлөвийг харна. Гүйлгээ хийх дарахад баталгаажуулах дэлгэц гарна.

ДЭЛГЭЦ 3/3 Гүйлгээний түүх




1 **Түүх**

Багц доторх бүх гүйлгээ амжилттай болсны дараа багц «Гүйлгээний түүх» рүү нэмэгдэнэ.

Апп доторх заавар

ЗАМ Шилжүүлэг › Багц шилжүүлэг

ДЭЛГЭЦ 1/11 **1. Шинээр багц гүйлгээ хийх**




1 Эхлэх

Эхний дэлгэцийн мэдээлэлтэй танилцаад Үргэлжлүүлэх-ийг дарна.

ДЭЛГЭЦ 2/11

2. Файл оруулах




1 **Файл хавсаргах**

Багц гүйлгээний төрөл, Шилжүүлэх данс-аа сонгоод бэлдсэн Excel файлаа хавсаргана. Файл бэлдээгүй бол Excel template товчоор төрөлд тохирох загварыг татаж, бичилтүүдээ оруулна.

ДЭЛГЭЦ 3/11

3. Файлын утга




1 **Утга**

Файл амжилттай хуулагдсаны дараа файлын утгыг оруулж үргэлжүүлнэ. Энэ нь зөвхөн файлын утга бөгөөд гүйлгээний утга биш.

ДЭЛГЭЦ 4/11

4. Үргэлжлүүлэх




1 **Амжилттай хуулсан**

Гарах цонхонд файлын нэр, хэмжээ, багц гүйлгээний төрөл харагдана. Эдгээрийг шалгаад Үргэлжлүүлэх-ийг дарна.

ДЭЛГЭЦ 5/11

5. Оруулсан файлын түүх




1 **Задалж байна**

Хуулсан файл «Оруулсан файлын түүх» рүү шилжиж, задлагдаж дуустал «Задалж байна» төлөвтэй байна. Дараа нь нийт дүнгээрээ барилт хийгдэж «Багц гүйлгээний жагсаалт» руу орно.

ДЭЛГЭЦ 6/11

6. Багц гүйлгээний жагсаалт




1 **Хүлээгдэж байна**

Амжилттай задалсан гүйлгээ «Хүлээгдэж байна» төлөвтэй орж, гүйлгээ эхэлмэгц «Гүйлгээ хийгдэж байна» болно. Хүснэгтэд огноо, гүйлгээний утга, төлөв, Дэлгэрэнгүй холбоос харагдана.

ДЭЛГЭЦ 7/11

7. Дэлгэрэнгүй




1 **Гүйлгээ хийх**

Багц доторх гүйлгээ бүрийн шилжүүлэх данс, хүлээн авах данс, дансны нэр, дүн, төлөв харагдана. Гүйлгээ хийх-ийг дарахад баталгаажуулах дэлгэц гарна.

ДЭЛГЭЦ 8 / 11

8. Баталгаажуулах




1 Шалгах

Гүйлгээ баталгаажуулах цонхонд мэдээллээ шалгаад Гүйлгээ хийх-ийг дарна.

ДЭЛГЭЦ 9 / 11

9. Амжилттай




1 Гүйлгээ эхэлнэ

Амжилттай цонх гарснаар барилт хийгдсэн дүнгийн дагуу гүйлгээ түс бүрчлэн хийгдэж эхэлнэ. Нүүр хуудас товчоор гарч, явцыг Багц гүйлгээний жагсаалт-аас төлвөөр нь хянана.

ДЭЛГЭЦ 10/11

11. Амжилттай гүйлгээний түүх




1 **Түүх**

Бүх гүйлгээ амжилттай болсны дараа багц «Гүйлгээний түүх» рүү нэмэгдэнэ. Мөрийг дэлгэхэд гүйлгээ хийсэн огноо, нийт гүйлгээний тоо, багцын дугаар, Дэлгэрэнгүй холбоос гарна.

ДЭЛГЭЦ 11/11

12. Зөвшөөрлийн дараалалтай бол



1 **Зөвшөөрөх**

Байгууллагын гүйлгээ зөвшөөрлийн дараалалтай бол багц гүйлгээг «Зөвшөөрөх гүйлгээ» цэсээс зөвшөөрнө. Бичилтүүдийг «Багц гүйлгээний жагсаалт»-аас дэлгэрэнгүй дарж харна.


Гүйлгээ зөвшөөрөх

Зөвшөөрлийн дараалалтай байгууллагад бусад хэрэглэгчийн илгээсэн гүйлгээг хянаж зөвшөөрөх эсвэл татгалзах.

ЗАМ Гүйлгээний хүсэлт › Зөвшөөрөх хүсэлт

ХОЛБООТОЙ ЗААВАР Илгээсэн хүсэлт · Гүйлгээний түүх · Багц шилжүүлэг

ДЭЛГЭЦ 1/3 Зөвшөөрөх хүсэлтийн жагсаалт



1 Гүйлгээний төрөл

“Гүйлгээний төрөл”-өөс төрлөө сонгож, харах хүсэлтээ шүүнэ. Анх “Бүгд” гэж харагдана.

2 Жагсаалт

Жагсаалтад гүйлгээний төрөл, огноо, хүсэлт илгээсэн хэрэглэгч, хүлээн авагч, дүн харагдана. Огноо болон хүсэлт илгээсэн баганын сумаар эрэмбэлж болно.

3 Сонгох

Мөрийн зүүн талын дугуй тэмдэг дээр дарж гүйлгээг сонгоно. Олон гүйлгээг зэрэг сонгож болох ба сонгосны дараа “Татгалзах”, “Гүйлгээ зөвшөөрөх” товч идэвхжинэ.


4 Татгалзах

Сонгосон гүйлгээг татгалзах бол “Татгалзах” товчийг дарна.

5 Гүйлгээ зөвшөөрөх

“Гүйлгээ зөвшөөрөх” товчийг дарж сонгосон гүйлгээг зөвшөөрнө. Олон гүйлгээ сонгосон бол бүгдийг зэрэг зөвшөөрнө.

Гүйлгээний дэлгэрэнгүй



1 Гүйлгээний мэдээлэл

Зарлага гарах данс, хүсэлт илгээсэн хэрэглэгч, хүсэлт илгээсэн огноо, цаг болон “Гүйлгээний хүсэлт илгээсэн” төлөвийг харна.

2 Зэрэглэл 1

“Зэрэглэл1” хэсэгт тухайн шатанд зөвшөөрөх хэрэглэгчид болон шаардлагатай зөвшөөрлийн тоо харагдана. Зөвшөөрсний дараа хэрэглэгчийн төлөв өөрчлөгдөнө.

3 Зэрэглэл 2

“Зэрэглэл2” хэсэгт хүлээгдэж буй зөвшөөрөл болон шаардлагатай зөвшөөрлийн тоо харагдана. Шат хооронд “Эсвэл” гэж байвал аль нэг шатны зөвшөөрөл хангалттай.

4 Гүйлгээ

Гүйлгээний дүн, хүлээн авагч, хүлээн авах банк, гүйлгээний утгыг харж шалгана.


5 Татгалзах

Гүйлгээг татгалзах бол “Татгалзах” товчийг дарна. Татгалзсан гүйлгээ хийгдэхгүй.

6 Зөвшөөрөх

Мэдээллээ шалгаад “Зөвшөөрөх” товчийг дарна. Дараагийн шатны зөвшөөрөл шаардлагатай бол гүйлгээ дараагийн шат руу шилжинэ.

Багц гүйлгээ зөвшөөрөх



1 Зөвшөөрлийн шат

“Хүлээгдэж буй зөвшөөрөл” хэсэгт зэрэглэл болон шаардлагатай зөвшөөрлийн тоо харагдана. Багц гүйлгээг мөн энэ дарааллаар зөвшөөрнө.

2 Багцын мэдээлэл

Баруун талд багцын нийт дүн, төрөл болон “Багц гүйлгээний дугаар” харагдана.

3 Шалгах

“Шалгах” товчийг дарж багц доторх гүйлгээнүүдийг харна. Гүйлгээний тоо, дүн болон хүлээн авагчийг файлтайгаа тулгана.

Багц шилжүүлэг →

4 Зөвшөөрөх

“Зөвшөөрөх” товчийг дарвал багц доторх бүх гүйлгээ хамт зөвшөөрөгдөнө. Татгалзах бол “Татгалзах” товчийг ашиглана.


Илгээсэн хүсэлт

Зөвшөөрлийн дараалалтай байгууллагын илгээсэн, зөвшөөрөл хүлээж буй гүйлгээнүүд.

ЗАМ Гүйлгээний хүсэлт › Илгээсэн хүсэлт


ХОЛБООТОЙ ЗААВАР Гүйлгээ зөвшөөрөх · Гүйлгээний түүх · Багц шилжүүлэг

ДЭЛГЭЦ 1/1 Илгээсэн хүсэлтийн жагсаалт




1 Гүйлгээний төрөл

“Гүйлгээний төрөл”-өөс төрлөө сонгож, илгээсэн хүсэлтээ шүүнэ. Анх “Бүгд” гэж харагдана.



2 Төрлүүд

Өөрийн данс хооронд, Банк дотор, Банк хооронд, Гадаад гүйлгээ, Цалингийн багц, Энгийн багц, MT101, UFF төрлөөс харах төрлөө сонгоно.



3 Илгээсэн хүсэлтийн жагсаалт

Зөвшөөрөл хүлээж буй өөрийн хүсэлтүүдийг харна. Жагсаалтад гүйлгээний төрөл, огноо, хүсэлт илгээсэн хэрэглэгч, хүлээн авагч, дүн харагдана.

4 Цуцлах

Хүсэлтээ сонгосны дараа “Цуцлах” товч идэвхжинэ. Товчийг дарж сонгосон хүсэлтээ цуцална.


Гүйлгээний түүх

Илгээсэн болон зөвшөөрсөн гүйлгээний хүсэлтийн түүх.

ЗАМ Гүйлгээний хүсэлт › Гүйлгээний түүх


ХОЛБООТОЙ ЗААВАР Илгээсэн хүсэлт

ДЭЛГЭЦ 1/1 Гүйлгээний түүх




1 **Гүйлгээний түүх**

“Илгээсэн гүйлгээ” табаас өөрийн илгээсэн гүйлгээг, “Зөвшөөрсөн гүйлгээ” табаас өөрийн зөвшөөрсөн гүйлгээг харна.



2 Зөвшөөрсөн гүйлгээ

“Зөвшөөрсөн гүйлгээ” табыг сонгож өөрийн зөвшөөрсөн гүйлгээг харна.



3 Жагсаалт

Жагсаалтад гүйлгээний төрөл, огноо, хүсэлт илгээсэн хэрэглэгч, хүлээн авагч, дүн харагдана. Огноо болон хүсэлт илгээсэн баганын сумаар эрэмбэлж болно.

Зээлээ харах, төлөх

Байгууллагын зээлийн данснууд, зээлийн дэлгэрэнгүй мэдээлэл, зээл төлөх, хаах.


ХОЛБООТОЙ ЗААВАР Данс, үлдэгдэл харах

ХУВИЛБАР 1 / 3

Жагсаалт, дэлгэрэнгүй

ЗАМ Зээл › Зээлийн жагсаалт

ДЭЛГЭЦ 1 / 2 **Зээлийн жагсаалт**




1 Зээл

Зээл бүрийн төрөл, дүн, зээл төлөх өдөр, нийт үлдэгдэл харагдана. Зээл дээр дарж зээлийн дэлгэрэнгүйг нээнэ.

2 Төлөх өдөр хүртэлх хоног

Зээл төлөх өдөр хүртэлх хоног өнгөөр тэмдэглэгдэнэ: ногоон нь үлдсэн хоног, улбар шар **өнөөдөр** нь төлөх өдөр өнөөдөр, улаан хасах тэмдэгтэй нь хэтэрсэн хоногийг заана.

Зээлийн дэлгэрэнгүй



1 Зээлийн данс

Зээлийн дансны дугаар, дансны нийт үлдэгдэл харагдана. Дугаарын хажуугийн дүрсээр дансны дугаарыг хуулна.

2 Хүү, хугацаа, төлөлт

Хуримтлагдсан хүү, зээл дуусах хугацаа, дараагийн төлөлтийн огноо харагдана.

3 Холбоосууд

Зээл төлөх / Хаах, **Дансны дэлгэрэнгүй**, **Эргэн төлөлтийн хуваарь** холбоосууд байна. Зээл төлөх, хаах алхмыг **Зээл төлөх**, **Зээл хаах** табаас үзнэ.

4 Дансны хуулга


Зээлийн дансны гүйлгээ огноо, харьцсан данс, гүйлгээний утга, дүнгээр жагсана. Бүх хуулгыг **Бүгд**-ээр харна.

ХУВИЛБАР 2 / 3

Зээл төлөх

ЗАМ Зээл › Зээл сонгох › Зээл төлөх / Хаах › Зээл төлөлт


ДЭЛГЭЦ 1 / 3 Зээл төлөх / Хаах



1 **Зээл төлөх / Хаах**

Зээлийн дэлгэрэнгүйн **Холбоосууд** хэсгээс **Зээл төлөх / Хаах**-ыг дарна.

Зээл төлөлт



1 **Харилцах данс**

Төлбөр гарах харилцах дансаа сонгоно. Сонгосон дансны үлдэгдэл баруун талд харагдана.

2 **Зээл төлөлт таб**

Зээл төлөлт таб сонгогдсон байна.

3 **Өрийн дүн**

Төлөх ёстой өрийн дүн харагдана.

4 **Төлөх дүн**


Төлөх дүнгээ оруулна.

5 **Зээл төлөх**

Дүн оруулсны дараа **Зээл төлөх** товч идэвхжинэ. Товчийг дарна.

ДЭЛГЭЦ 3/3

Төлөлт амжилттай



1 **Амжилттай**

Зээл төлөлт амжилттай хийгдлээ гэсэн цонх гарна.

2 **Зээл цэс рүү шилжих**


Зээлийн жагсаалт руу буцна. Нүүр хуудас руу шилжих бол **Нүүр хуудас**-ыг дарна.

ХУВИЛБАР 3 / 3

Зээл хаах

ЗАМ Зээл › Зээл сонгох › Зээл төлөх / Хаах › Зээл хаах

ДЭЛГЭЦ 1 / 2 **Зээл хаах**



1 Зээл хаах таб

Зээл төлөх / Хаах хуудасны **Зээл хаах** табыг сонгоно.

2 Харилцах данс

Төлбөр гарах харилцах дансаа сонгоно.

3 Зээл хаах дүн

Зээлийг бүрэн хаахад төлөх дүн харагдана.


4 Хүү, үлдэгдэл

Хуримтлагдсан хүү, зээлийн нийт үлдэгдэл харагдана. Зээл хаах дүн нь эдгээрийн нийлбэр байна.

5 Зээл хаах

Мэдээллээ шалгаад **Зээл хаах** товчийг дарна.

ДЭЛГЭЦ 2/2 **Зээл хаагдлаа**



1 **Амжилттай**

Та амжилттай зээлээ хаалаа гэсэн цонх гарна.

2 **Зээл цэс рүү шилжих**

Зээлийн жагсаалт руу буцна. Нүүр хуудас руу шилжих бол **Нүүр хуудас**-ыг дарна.

Картын удирдлага

Дебит, кредит, виртуал картаа харах, идэвхгүй болгох, ПИН код авах, шинэ карт идэвхжүүлэх, кредит картын төлбөр төлөх.


ХОЛБООТОЙ ЗААВАР Данс, үлдэгдэл харах · Гүйлгээний загвар

ХУВИЛБАР 1 / 6

Жагсаалт, дэлгэрэнгүй

ЗАМ Картын удирдлага › Дебит / Кредит / Виртуал

ДЭЛГЭЦ 1 / 2 **Картын жагсаалт**




1 Картын төрөл
Дебит, **Кредит**, **Виртуал** табаар шүүнэ. Анх **Дебит** таб сонгогдсон байна.

2 Карт
Карт бүр нууцлагдсан дугаар, үндсэн данс, валют, боломжит үлдэгдэлтэйгээ харагдана. Карт дээр дарж дэлгэрэнгүйг нээнэ.

3 Төлөв
Унтраалга асаалттай бол карт идэвхтэй, унтраалттай бол идэвхгүй байна.

Картын дэлгэрэнгүй



1 Картын мэдээлэл

Картын дугаар, дуусах хугацаа, CVV код нууцлагдсан байдлаар харагдана. Дэлгэрэнгүй мэдээллийг аппаас харна.

2 Үндсэн данс

Картын үндсэн данс, валют, боломжит үлдэгдэл харагдана.

3 Картын тохиргоо

Картын төлөв, шинэ ПИН код авах, шинэ И-ПИН код авах тохиргоо байна. Үйлдэл түс бүрийн алхмыг дээрх табуудаас үзнэ.


4 Картын хуулга

Картаар хийгдсэн гүйлгээ огноо, хүлээн авагчийн данс, гүйлгээний утга, дүнгээр жагсана.

Идэвхгүй / идэвхтэй болгох


ЗАМ Картын удирдлага › Карт сонгох › Картын тохиргоо › Картын төлөв

ДЭЛГЭЦ 1/2 Картаа идэвхгүй болгох



1 **Картын төлөв**

Картын төлөв (Идэвхтэй) унтраалгыг дарна.




2 **Картаа идэвхгүй болгох уу?**

Карт идэвхгүй болсноор ажиллахгүй болох тухай цонх гарна. Болих бол **Үгүй**-г дарна.

3 **Тийм**

Тийм-г дарж баталгаажуулна.




4 **Карт идэвхгүй боллоо**

Баруун дээд буланд мэдэгдэл гарна. Картын төлвийг идэвхтэй болгож дахин ашиглах боломжтой.

5 **Карт нөхөн захиалах**


Идэвхгүй картын тохиргоонд **Карт нөхөн захиалах** сонголт гарна.

Картаа идэвхтэй болгох



1 Картын төлөв

Картын төлөв (Идэвхгүй) унтраалгыг дарна.




2 Картаа идэвхтэй болгох уу?

Идэвхжүүлэх картын мэдээлэл зөв эсэхийг шалгана. Болих бол **Буцах**-ыг дарна.

3 Тийм

Тийм-г дарж баталгаажуулна.



4 **Карт идэвхтэй боллоо**


Та тухайн картыг төлбөр, тооцоонд ашиглах боломжтой боллоо гэсэн мэдэгдэл гарна.

ХУВИЛБАР 3 / 6

Шинэ ПИН код


ЗАМ Картын удирдлага › Карт сонгох › Картын тохиргоо › Шинэ пин код авах

ДЭЛГЭЦ 1 / 3 **Шинэ ПИН код авах**



1 **Шинэ пин код авах**

Картын тохиргооноос **Шинэ пин код авах**-ыг дарна.




2 **Утасны дугаар шалгах**

Шинэ ПИН код бүртгэлтэй утасны дугаарт илгээгдэнэ. Цонхонд утасны дугаар, картын дугаар нууцлагдсан байдлаар харагдана.

3 **Тийм**

Тийм-г дарж үргэлжлүүлнэ.


ДЭЛГЭЦ 2/3 Баталгаажуулах суваг



1 **Баталгаажуулах суваг**

Мессеж эсвэл **HID Authenticator** сувгийн аль нэгийг сонгон баталгаажуулна. Мессеж сонговол бүртгэлтэй утсанд код ирж, HID Authenticator сонговол HID Approve аппаар баталгаажуулна.

Шинэ ПИН код илгээгдлээ



1 **Амжилттай**


Таны гар утасны дугаарт шинэ пин кодыг илгээлээ гэсэн мэдэгдэл гарна.

ХУВИЛБАР 4 / 6

Шинэ И-ПИН код


ЗАМ Картын удирдлага › Карт сонгох › Картын тохиргоо › Шинэ и-пин код авах

ДЭЛГЭЦ 1 / 3 Шинэ И-ПИН код авах



1 Шинэ и-пин код авах

Картын тохиргооноос **Шинэ и-пин код авах**-ыг дарна.




2 **Баталгаажуулах**

И-ПИН код одоо байгаа картын ПИН кодтой адилхан болж өөрчлөгдөнө гэсэн цонх гарна. Болих бол **Үгүй**-г дарна.

3 **Үргэлжлүүлэх**

Үргэлжлүүлэх-ийг дарна.

ДЭЛГЭЦ 2/3 Баталгаажуулах суваг




1 **Баталгаажуулах суваг**

Мессеж эсвэл **HID Authenticator** сувгийн аль нэгийг сонгон баталгаажуулна. Мессеж сонговол бүртгэлтэй утсанд код ирж, HID Authenticator сонговол HID Approve аппаар баталгаажуулна.

ДЭЛГЭЦ 3/3

И-ПИН код шинэчлэгдлээ




1 **Амжилттай**

Таны И-Пин кодыг картын пин кодтой адилхан болголоо гэсэн мэдэгдэл гарна.

Шинэ карт идэвхжүүлэх

ЗАМ Картын удирдлага › Дебит › Идэвхжүүлэх


ДЭЛГЭЦ 1 / 4 Шинэ карт



1 **Идэвхжүүлэх**


Шинээр захиалсан картын мөрөнд **Идэвхжүүлэх** товч гарна. Дарахад картын захиалгын явц нээгдэнэ.

Захиалгын явц



1 Гүйлгээний явц


Картын захиалгын шат (**Карт захиалсан**, **Карт хэвлэгдсэн** гэх мэт) харагдана. Карт хэвлэгдэх хүртэл **Карт идэвхжүүлэх** товч идэвхгүй байна.



2 Карт идэвхжүүлэх

Карт хэвлэгдсэний дараа **Карт идэвхжүүлэх** товч идэвхжинэ. Товчийг дарна.

ДЭЛГЭЦ 3/4 **Картаа идэвхжүүлэх**




1 **Картаа идэвхжүүлэх үү?**

Идэвхжүүлэх картын мэдээлэл зөв эсэхийг шалгана. Болих бол **Үгүй**-г дарна.

2 **Тийм**

Тийм-г дарж баталгаажуулна.

ДЭЛГЭЦ 4/4 **Карт идэвхжлээ**




1 **Картын төлөв**

Картын төлөв **Идэвхтэй** болж, картын тохиргоо нээгдэнэ.

Кредит карт

ЗАМ Картын удирдлага › Кредит › Карт сонгох › Төлбөр төлөх

ДЭЛГЭЦ 1 / 4 Кредит картын жагсаалт




1 **Кредит таб**

Кредит табыг сонгоно.

2 **Кредит карт**

Карт бүр нууцлагдсан дугаар, үндсэн данс, валют, боломжит үлдэгдэл, төлөвтэйгөө харагдана. Карт дээр дарж дэлгэрэнгүйг нээнэ.

Кредит картын дэлгэрэнгүй




1 **Картын мэдээлэл**

Ашиглах боломжтой дүн, кредит картын нийт эрх, төлөх доод дүн, нийт төлөх дүн харагдана.

2 **Дэлгэрэнгүй харах**


Дэлгэрэнгүй харах-ыг дарж төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг нээнэ.



3 **Төлбөрийн дэлгэрэнгүй**


Нэхэмжилсэн өдөр, төлбөр төлөх сүүлийн өдөр, ашигласан бэлэн болон бэлэн бус гүйлгээ, төлөгдсөн төлбөр, хүү шимтгэл харагдана. **Хураангуйлах**-аар хураана.

Кредит картын төлбөр төлөх



1 **Төлбөр төлөх**

Картын тохиргооноос **Төлбөр төлөх**-ийг дарна.



2 **Харилцах данс**

Төлбөр төлөх харилцах дансаа сонгоно. Сонгосон дансны үлдэгдэл баруун талд харагдана.


3 **Шилжүүлэх дүн**

Төлөх дүнгээ оруулна.

4 **Шилжүүлэх**

Мэдээллээ шалгаад **Шилжүүлэх** товчийг дарна.

Төлбөр төлөгдлөө



1 **Зээлийн картын төлбөр төлөгдлөө**

Төлбөр төлөгдсөний дараа хүлээн авагч банк, дансны дугаар, гүйлгээний утга, журнал дугаар, огноо, шимтгэл харагдана.

2 **Дуусгах**

Дуусгах-ыг дарж цонхыг хаана.


Татвар төлөх

Татварын ерөнхий газрын нэхэмжлэлийг регистр, нэхэмжлэл эсвэл хөрөнгийн дугаараар хайж төлөх.

ЗАМ Төлбөр › Татвар

ХОЛБООТОЙ ЗААВАР Гаалийн төлбөр төлөх

ДЭЛГЭЦ 1/3 Хайх төрлөө сонгох




1 Хайх төрөл

Дээд хэсгийн гурван табын аль нэгийг сонгоно: **Регистрийн дугаар**, **Нэхэмжлэлийн дугаар**, **Хөрөнгийн дугаар**.


2 Регистрийн дугаар

Байгууллагын регистр автоматаар бөглөгдсөн байна. Регистрээр хайхад тухайн татвар төлөгчийн бүх нээлттэй нэхэмжлэл гарна.



3 Хөрөнгийн дугаар


Хөрөнгийн дугаар табыг сонгоод хөрөнгийн татварыг хөрөнгийн дугаараар хайна. Дугаар оруулсны дараа **Үргэлжлүүлэх** товч идэвхжинэ.



4 Үргэлжлүүлэх

Үргэлжлүүлэх-ийг дарж хайна. Нэхэмжлэл олдвол 2/3 алхам буюу **Татварын мэдээлэл** рүү шилжинэ.

ДЭЛГЭЦ 2/3 **Нэхэмжлэлийн дугаараар хайх**



1 Нэхэмжлэлийн дугаар

Нэхэмжлэлийн дугаар табыг сонгоно. Тодорхой нэг нэхэмжлэлийг төлөх үед энэ аргыг хэрэглэнэ.

2 Дугаар


Нэхэмжлэлийн дугаараа татварын нэхэмжлэл дээрх дугаартай яг адил, зай, илүү тэмдэгтгүй оруулна.

3 Үргэлжлүүлэх

Үргэлжлүүлэх-ийг дарж хайна. Нэхэмжлэл олдвол 2/3 алхамд татвар төлөгчийн мэдээлэл, нэхэмжлэлийн жагсаалт гарна.

ДЭЛГЭЦ 3/3

Татварын мэдээлэл



1 Татвар төлөгч

Татвар төлөгчийн мэдээлэл хэсэгт **Бүтэн нэр** болон **Регистрийн дугаар** харагдана.

2 Нэхэмжлэл

Нэхэмжлэлийн төрөл, дугаар, хүлээн авагчийн данс, татварын дүн харагдана. Төлөх нэхэмжлэлээ чагтлан сонгоно.

3 Нийт дүн

Нэхэмжлэл чагтлахад **Сонгосон татварын тоо**, **Шимтгэлийн дүн**, **Нийт дүн** шинэчлэгдэнэ.

4 Данс

ХАРИЛЦАХ ДАНС хэсгийг дарж төлбөр гарах дансаа сонгоно. Сонгосон дансны **Боломжит үлдэгдэл** харагдана.

5 Үргэлжлүүлэх

Нэхэмжлэл сонгосны дараа **Үргэлжлүүлэх** товч идэвхжинэ. Дарж 3/3 алхам руу шилжинэ.


Гаалийн төлбөр төлөх

Гаалийн ерөнхий газрын нэхэмжлэлийг регистр, нэхэмжлэхийн дугаар эсвэл баркодоор хайж төлөх.

ЗАМ Төлбөр › Гааль

ХОЛБООТОЙ ЗААВАР Татвар төлөх

ДЭЛГЭЦ 1/3 Хайх төрлөө сонгох




1 Хайх төрөл

Дээд хэсгийн гурван табын аль нэгийг сонгоно: **Регистрийн дугаар**, **Нэхэмжлэхийн дугаар**, **Баркод**.


2 Регистрийн дугаар

Регистрийн дугаар табад байгууллагын регистр автоматаар бөглөгдсөн байх тул шууд **Үргэлжлүүлэх**-ийг дарж болно. Байгууллагын нэр дээр үүссэн гаалийн нэхэмжлэлүүд гарна.



3 Баркод


Баркод табыг сонгоод гаалийн баримт дээрх баркодын дугаарыг яг адил оруулна. Дугаар оруулсны дараа **Үргэлжлүүлэх** товч идэвхжинэ.



4 Үргэлжлүүлэх

Үргэлжлүүлэх-ийг дарж хайна. Нэхэмжлэл олдвол 2/3 алхам руу шилжиж төлөгчийн мэдээлэл, нэхэмжлэлийн жагсаалт гарна.

ДЭЛГЭЦ 2/3 **Нэхэмжлэхийн дугаараар хайх**



1 **Нэхэмжлэхийн дугаар**

Нэхэмжлэхийн дугаар табыг сонгоно. Тодорхой нэг гаалийн нэхэмжлэхийг төлөх үед энэ аргыг хэрэглэнэ.

2 **Дугаар**


Нэхэмжлэхийн дугаарыг оруулна. Дугаар үсэг агуулж болно.

3 **Үргэлжлүүлэх**

Үргэлжлүүлэх-ийг дарж хайна. Нэхэмжлэх олдвол 2/3 алхамд гаалийн мэдээлэл гарна.

ДЭЛГЭЦ 3 / 3

Гаалийн мэдээлэл



1 Төлөгч

Татварын мэдээлэл хэсэгт төлөгчийн **Бүтэн нэр**, **Регистрийн дугаар** харагдана.

2 Нэхэмжлэл

Гаалийн газар, огноо, нэхэмжлэлийн төрөл, нэхэмжлэхийн дугаар, дүн харагдана. Төлөх нэхэмжлэлээ сонгоно.

3 Нийт дүн

Нэхэмжлэл сонгоход **Сонгосон татварын тоо**, **Шимтгэлийн дүн**, **Нийт дүн** шинэчлэгдэнэ.

4 Данс

ХАРИЛЦАХ ДАНС хэсгийг дарж төлбөр гарах дансаа сонгоно. Сонгосон дансны **Боломжит үлдэгдэл** харагдана.

5 Үргэлжлүүлэх

Нэхэмжлэл сонгосны дараа **Үргэлжлүүлэх** товч идэвхжинэ. Дарж 3/3 алхам руу шилжинэ.

Мэдэгдэл, хүсэлт илгээх

Банкнаас ирсэн мэдэгдлээ харах, банкинд хүсэлт илгээх.


ХОЛБООТОЙ ЗААВАР Арилжааны хүсэлт

ХУВИЛБАР 1/2

Мэдэгдэл

ЗАМ Үйлчилгээ › Хүсэлт / Мессеж › Мэдэгдэл

ДЭЛГЭЦ 1/1 **Мэдэгдэл**



1 **Мэдэгдэл / Хүсэлт**

Үйлчилгээ → Хүсэлт / Мессеж цэсэд **Мэдэгдэл**, **Хүсэлт** табууд байна. **Мэдэгдэл** табын хажууд уншаагүй мэдэгдлийн тоо улаан тэмдэгтэйгээр харагдана.


2 **Мэдэгдэл**

Аюулгүй байдлын болон бусад мэдэгдэл **Өнөөдөр** гэх мэт огнооны бүлгээр, гарчиг, товч агуулга, цагтайгаа жагсана. Уншаагүй мэдэгдлийн өмнө цэнхэр цэг байна.

Хүсэлт илгээх

ЗАМ Үйлчилгээ › Хүсэлт / Мессеж › Хүсэлт

ДЭЛГЭЦ 1/2 Хүсэлтийн жагсаалт



1 **Хүсэлт**

Хүсэлт табыг сонгоно. Энд банкинд өмнө илгээсэн хүсэлтүүдээ харж, шинээр хүсэлт үүсгэнэ.


2 **Жагсаалт**

Илгээсэн хүсэлтүүд энэ жагсаалтад нэмэгдэж харагдана.

3 **Хүсэлт шинээр үүсгэх**


Баруун дээд буланд байрлах **Хүсэлт шинээр үүсгэх** товчийг дарна. **Хүсэлт үүсгэх** маягт нээгдэнэ.

Хүсэлт бөглөх




1 Төрөл

Төрөл сонгох талбарыг дарж, хүсэлтийнхээ агуулгад тохирох төрлийг жагсаалтаас сонгоно.



2 Төрлүүд

Маргаантай гүйлгээ, Бэлэн мөнгө авах, Санал хүсэлт, Гомдол, Талархал гэх мэт төрөл байна. Бүх төрлийг харахын тулд жагсаалтыг доош гүйлгэнэ.



3 Тайлбар

Тайлбар талбарт хүсэлтээ тодорхой бичнэ. Гүйлгээтэй холбоотой бол огноо, дүн зэрэг мэдээллийг оруулна.

4 Хүсэлт үүсгэх

Хүсэлт үүсгэх товчийг дарна. Хүсэлт банкинд илгээгдэж, **Хүсэлт** табын жагсаалтад нэмэгдэнэ.


Кастодиан

Кастодианы дансны хөрөнгө, үнэт цаасны гүйлгээ, тайлан.

ЗАМ Үйлчилгээ › Кастодиан

ХОЛБООТОЙ ЗААВАР Данс, үлдэгдэл харах

ДЭЛГЭЦ 1/3 **Хөрөнгийн жагсаалт**



1 Нийт хөрөнгө

Нийт хөрөнгө хэсэгт кастодианы данс дахь хөрөнгийн нийт дүн төгрөгөөр харагдана.

2 Табууд

Анх **Хөрөнгийн жагсаалт** таб сонгогдсон байна. **Үнэт цаасны гүйлгээ** табаас арилжааны түүхээ, **Тайлан** табаас тайлангаа авна.

3 Багануud тохируулах

Багануud тохируулах товчоор хүснэгтэд харагдах баганууdыг сонгоно. Зүүн талын татах дүрсээр хүснэгтийн мэдээллийг файлаар татаж авна.


4 Хайх

Хайлтын талбарт үнэт цаасны нэр эсвэл төрлөө бичихэд хүснэгт шүүгдэнэ.

5 Хүснэгт

Хүснэгтэд үнэт цаас, төрөл, хаалтын ханш, зах зээлийн үнэлгээ, нийт номинал, хуримтлагдсан хүү, PL харагдана. Баганын нэрийн хажуудах сумаар эрэмбэлнэ.


ДЭЛГЭЦ 2/3 **Үнэт цаасны гүйлгээ**



1 **Гүйлгээ**

Эхлэх огноо, **Дуусах огноо**-г календараас сонгож хугацаагаа тогтооно. Хайлтын талбараар үнэт цаас эсвэл гүйлгээний ID-гаар хайна.

ДЭЛГЭЦ 3/3 **Тайлан**



1 **Тайлан**

Хэл сонгох, **Огноо сонгох**, **Тайлангийн төрөл сонгох**, **Формат сонгох** талбаруудыг сонгоод **Тайлан авах**-ыг дарна.


Арилжааны хүсэлт

Валют хооронд хөрвүүлэх гүйлгээнд банкнаас ханш авах хүсэлт илгээх.

ЗАМ Үйлчилгээ › Арилжаа хийх

ХОЛБООТОЙ ЗААВАР Гадаад руу шилжүүлэх (SWIFT) · Дотоод шилжүүлэг хийх

ДЭЛГЭЦ 1/3 Хүсэлтийн жагсаалт



1 Хүсэлтүүд


Таны үүсгэсэн арилжааны хүсэлтүүд энд жагсана.

2 Хүсэлт үүсгэх

Хүсэлт үүсгэх-ийг дарахад арилжааны хүсэлтийн маягт нээгдэнэ.


ДЭЛГЭЦ 2/3

Хүсэлт үүсгэх




1 Гүйлгээний төрөл

Гүйлгээний төрөл талбарыг дарж арилжааны төрлөө сонгоно. Сонгосон төрлөөс хамааран хүлээн авах дансны талбарууд нэмэгдэнэ.



2 Төрлүүд


Өөрийн данс хооронд, Бусдын данс, Гадаад шилжүүлэг гэсэн төрөл байна. Гадаад шилжүүлгийн хүлээн авагчийн мэдээллийг хүсэлт батлагдсаны дараа оруулна.



3 **Бэлэн бус ханш**

Маягтын баруун талд валют бүрийн **Албан** ханш болон банкны авах, зарах ханш харагдана. **Шинэчлэх**-ийг дарж сүүлийн ханшийг харна.

Маягт бөглөх



1 Шилжүүлэх данс

Шилжүүлэх данс-ыг дарж мөнгө гарах дансаа сонгоно. Сонгосон дансны баруун талд **Боломжит үлдэгдэл** харагдана.

2 Хүлээн авах данс

Шилжүүлэх данснаас өөр валютын хүлээн авах дансаа сонгоно. Дансны IBAN, нэр, валют харагдана.

3 Илгээх / Хүлээн авах


Тодорхой хэмжээний мөнгө гаргах бол **Илгээх**, хүлээн авагчид тодорхой дүн хүргэх бол **Хүлээн авах**-ыг сонгоно. Анх **Илгээх** сонгогдсон байна.

4 Данснаас хасагдах дүн

Данснаас хасагдах дүн хэсэгт шилжүүлэх данснаас гарах дүнгээ тухайн дансны валютаар оруулна.

5 Хүлээн авах дүн

Хүлээн авах дүн талбарыг бөглөхгүй. Хүсэлтийг хянаж ханшаа тогтоосны дараа банк хүлээн авах дүнг оруулна.



6 Гүйлгээний утга

Гүйлгээний утга талбарт гүйлгээний зорилгыг товч, ойлгомжтой бичнэ.

7 Хүсэлт үүсгэх

Хүсэлт үүсгэх-ийг дарна. Хүсэлт банкинд илгээгдэж, банк хүсэлтийг хянан ханшаа санал болгоно.


Хувийн мэдээлэл

Байгууллагын бүртгэлтэй мэдээллийг харах, профайлын зураг солих.

ЗАМ Тохиргоо › Хувийн мэдээллийн тохиргоо

ХОЛБООТОЙ ЗААВАР Дансны тохиргоо · Аюулгүй байдлын тохиргоо

ДЭЛГЭЦ 1/1 Хувийн мэдээллийн тохиргоо



1 Тохиргооны цэс

Тохиргоо цэсний **Хувийн мэдээллийн тохиргоо**-г сонгоно. Баруун талд профайлын зураг, нэр болон үндсэн мэдээлэл харагдана.

2 Бүртгэлтэй мэдээлэл

Үндсэн мэдээлэл хэсэгт утасны дугаар, и-мэйл хаяг, байгууллагын нэр, регистрийн дугаар харагдана. Эдгээрийг онлайнаар засах боломжгүй, шинэчлүүлэх бол банкинд хандана.

3 Зураг солих

Профайлын зургийн баруун талын **Зураг солих** товчийг дарж профайлын зургаа солино.

Дансны тохиргоо

Гүйлгээ хийх, үлдэгдэл шалгахад автоматаар сонгогдох үндсэн дансаа тохируулах.


ХОЛБООТОЙ ЗААВАР Данс, үлдэгдэл харах · Интернэт банкинд нэвтрэх

ХУВИЛБАР 1/1

Үндсэн данс

ЗАМ Тохиргоо › Дансны тохиргоо › Үндсэн данс сонгох

ДЭЛГЭЦ 1/4 **Үндсэн данс сонгох**




1 Үндсэн данс сонгох

Тохиргоо → Дансны тохиргоо → Үндсэн данс сонгох цэсээр орно.

2 Одоогийн үндсэн данс

Данс бүрийн мөрөнд дансны дугаар, үлдэгдэл, дансны төрөл харагдана. Одоогийн үндсэн данс сонгогдсон байна.

ДЭЛГЭЦ 2/4 **Өөр данс сонгох**




1 **Данс**

Үндсэн болгох дансны мөрийн баруун талын дугуй тэмдгийг дарж сонгоно.

2 **Сонгох**

Идэвхжсэн **Сонгох** товчийг дарна. Баталгаажуулах цонх гарна.

Баталгаажуулах




1 **Үндсэн данс болгох уу?**

Цонхонд үндсэн болгох гэж буй дансны дугаар харагдана.

2 **Сонгох**

Цонхны **Сонгох**-ыг дарж баталгаажуулна. Сонгосон данс үндсэн данс болж хадгалагдана.

Бүртгэл амжилттай




1 **Бүртгэл амжилттай**

Цонхонд үндсэн дансаар сонгогдсон дансны дугаар харагдана.

2 **Нүүр хуудас**

Нүүр хуудас-ыг дарж нүүр хуудас руу шилжинэ.



3 **Нүүр хуудсанд**

Нүүр хуудасны **Үндсэн данс** хэсэгт шинэ дансны үлдэгдэл, дугаар болон **Шилжүүлэг хийх** товч харагдана.

Аюулгүй байдлын тохиргоо

Нууц үг, HID давхар баталгаажуулалт, бүртгэлтэй төхөөрөмж, онлайн бүртгэлээ удирдах.


ХОЛБООТОЙ ЗААВАР HID Approve-д бүртгүүлэх · Нууц үг сэргээх · Хувийн мэдээлэл

ХУВИЛБАР 1 / 4

Нууц үг солих

ЗАМ Тохиргоо › Аюулгүй байдлын тохиргоо › Нууц үг солих

ДЭЛГЭЦ 1 / 3 **Нууц үг солих**




1 Нууц үг солих
Тохиргоо → Аюулгүй байдлын тохиргоо → Нууц үг солих цэсээр орно. Гурван талбар бүхий маягт нээгдэнэ.

2 Одоогийн нууц үг
Одоо ашиглаж буй нууц үгээ оруулна. Талбарын баруун талын нүдэн дүрсээр оруулсан нууц үгээ харж болно.

3 Шинэ нууц үг
Шинэ нууц үгээ оруулна. Нууц үг 8–20 тэмдэгттэй, дор хаяж 1 том үсэг, 1 жижиг үсэг, 1 тоо, 1 тусгай тэмдэгт агуулна.

4 Нууц үгээ давтах
Шинэ нууц үгээ яг адилаар давтан оруулна.

Шинэчлэх




1 Бөглөсөн талбарууд

Гурван талбар бөглөгдсөн байна. Талбарын баруун талын X тэмдгээр утгыг арилгаж, нүдэн дүрсээр нууц үгээ харж болно.

2 Шинэчлэх

Шинэчлэх-ийг дарна. Шинэ нууц үг шаардлага хангаж байвал нууц үг амжилттай солигдоно.

Амжилттай солигдлоо



1 **Нууц үг амжилттай солигдлоо**

Нууц үг солигдож, бүртгэлтэй и-мэйлд **Нууц үг шинэчлэгдлээ** мэдэгдэл очно. Дараагийн удаа шинэ нууц үгээрээ нэвтэрнэ.


2 **Нүүр хуудас**

Нүүр хуудас-ыг дарж нүүр хуудас руу шилжин онлайн банкаа үргэлжлүүлэн ашиглана.

Давхар баталгаажуулалт


ЗАМ Тохиргоо › Аюулгүй байдлын тохиргоо › Давхар баталгаажуулалт

ДЭЛГЭЦ 1/2 Танилцуулга




1 **1. Давхар баталгаажуулалт**

TDB OTP, Vasco төхөөрөмжийг орлох HID Approve аппаар нэвтрэх, гүйлгээг баталгаажуулна. **Дараах**-аар дараагийн хуудас руу шилжиж, **Алгасах**-аар танилцуулгыг алгасна.



2 **2. Ашиглалт**


HID Approve-оор **Өндөр дүнтэй гүйлгээ хийх**, **Нууц үг шинэчлэх**, **Нэвтрэх нэр сэргээх** үйлдлийг баталгаажуулна.



3 **3. Хэрхэн бүртгүүлэх**

Аюулгүй байдлын тохиргоо цэсний **Давхар баталгаажуулалт**-аар гар утсандаа бүртгүүлнэ. Бүртгэлийг QR код эсвэл гараар хийх боломжтой.

HID Approve-д бүртгүүлэх →



4 **4. Хэрхэн ашиглах**


Нэвтрэх эсвэл гүйлгээ баталгаажуулах үед HID Approve апп дээр хүсэлт ирж, **Approve** товчийг гулсуулж зөвшөөрнө.

5 **Дахин харуулахгүй байх**

Сүүлийн хуудсанд **Дахин харуулахгүй байх**-ыг чагталбал танилцуулга дахин автоматаар гарахгүй. ⓘ дүрсээр дахин нээнэ.

ДЭЛГЭЦ 2/2

Бүртгэлтэй HID төхөөрөмж



1 **Төхөөрөмж**


Мөрөнд бүртгэлтэй HID төхөөрөмжийн нэр болон бүртгэсэн огноо, цаг харагдана.

2 **Төлөв**

ИДЭВХТЭЙ төлөвтэй төхөөрөмжөөр баталгаажуулалт хийнэ, **ИДЭВХГҮЙ** бол тухайн төхөөрөмжөөр баталгаажуулалт хийх боломжгүй.

3 ⓘ

Давхар баталгаажуулалт гарчгийн баруун талын ⓘ дүрсийг дарж танилцуулгыг дахин нээнэ.



4 **Дэлгэрэнгүй**

Сумаар дэлгэхэд **Төхөөрөмжийн дугаар**, **Бүртгэсэн огноо** болон **Идэвхгүй болгох** товч гарна.

5 **Идэвхгүй болгох**


Идэвхгүй болгох-ыг дарж, гарч ирэх цонхонд дахин баталгаажуулна. Идэвхгүй болгосон төхөөрөмжийг **Идэвхтэй болгох**-оор сэргээнэ.

ХУВИЛБАР 3 / 4

Бүртгэлтэй төхөөрөмж


ЗАМ Тохиргоо › Аюулгүй байдлын тохиргоо › Бүртгэлтэй төхөөрөмж

ДЭЛГЭЦ 1 / 1 Бүртгэлтэй төхөөрөмж



1 Төхөөрөмж

Мөрөнд хадгалсан төхөөрөмжийн үйлдлийн систем, хөтчийн нэр болон хадгалсан огноо харагдана.



2 Дэлгэрэнгүй

Мөрийг сумаар дэлгэхэд **IMEI дугаар / IP хаяг**, **Төхөөрөмжийн мэдээлэл**, **Төлөв**, **Сүүлд хандсан огноо** болон **Устгах** товч гарна.


3 Устгах

Танихгүй төхөөрөмжийг **Устгах** товчоор устгана. Устгасан төхөөрөмжөөс нэвтрэх бүрд OTP-оор баталгаажуулна.

Бүртгэл идэвхгүй болгох

ЗАМ Тохиргоо › Аюулгүй байдлын тохиргоо › Бүртгэл устгах

ДЭЛГЭЦ 1/3 Бүртгэл идэвхгүй болгох



1 **Бүртгэл устгах**

Аюулгүй байдлын тохиргоо доторх **Бүртгэл устгах** цэсийг сонгоно. Энэ үйлдлээр бүртгэл бүрмөсөн устахгүй, түр идэвхгүй болно.


2 **Тайлбар**

Зөвшөөрөлгүй хандалт, гүйлгээнээс сэргийлж онлайн банкны бүртгэлээ түр хаах боломжтой.

3 **Идэвхгүй болгох**

Идэвхгүй болгох-ыг дарна. Баталгаажуулах цонх гарна.


Баталгаажуулах



1 **Идэвхгүй болгох**

Идэвхгүй болгох-ыг дарж баталгаажуулна. Бүртгэл идэвхгүй болж, онлайн банкнаас автоматаар гарна.

И-банкны эрх цуцлагдлаа



1 **Статус шинэчлэгдлээ**

Дэлгэцийн баруун дээд буланд **Хэрэглэгчийн статус амжилттай шинэчлэгдлээ** мэдэгдэл гарч, **И-банкны эрх цуцлагдлаа** цонх нээгдэнэ.

2 **И-банкны эрх цуцлагдлаа**

Бүртгэлтэй и-мэйл, утсанд **Бүртгэл түр идэвхгүй боллоо** мэдэгдэл очно. Эрхээ дахин нээлгэхийн тулд салбарт хандана.

3 **Ойлголоо**

Ойлголоо-г дарахад онлайн банкнаас гарч нэвтрэх хуудас нээгдэнэ.